



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



*Empowered lives.
Resilient nations.*

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

“БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ УДИРДЛАГЫГ ХАНГАХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ ТӨСӨЛ”

ЗӨВЛӨХ: Б.МЭНДБАЯР

ХЯНАСАН: Д.ЖАВХЛАНБОЛД



УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

АГУУЛГА

Өмнөтгөл	6
ОРШИЛ	7
Талархал	8
Судалгааны ажлын зорилго, ач холбогдол	9
Сэдвийн судлагдсан байдал	9
Судалгааны арга зүй	10
Сэдвийн хамрах хүрээ	11
Судалгааны хязгаарлагдмал байдал ба хүндрэл бэрхшээл	11

I БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Уул уурхайн салбарын статистик үзүүлэлтүүд	12
1.2 Уул уурхайн салбарын эрх зүйн орчин	18
1.3 Уул уурхайн авлигын эрсдлийн үнэлгээ	22

II БҮЛЭГ. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

1.1 Хариуцлагын тухай ойлголт ба түүний мөн чанар	24
2.2 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл ба эрсдэл	26
2.3 Уул уурхайн үйл ажиллагааны зөрчлийн өртөг	36

III БҮЛЭГ. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ БА САНААЧИЛГА

3.1 Уул уурхайн хариуцлагыг сайжруулах санаачилгын ач холбогдол	41
3.2 Хариуцлагатай уул уурхайн Монгол Улсын туршлага	42
3.3 Хариуцлагатай уул уурхайн олон улсын туршлага	46
3.4 Хариуцлагатай уул уурхайн харьцуулсан шинжилгээ, үр дүн	65
Дүгнэлт	80
Хариуцлагатай уул уурхайн хамрах хүрээ ба шаардлага	83
Ном зүй	99
Хариуцлагатай уул уурхайн жишиг шалгуурыг туршсан үр дүн	119

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГ	Ашигт малтмалын газар
АНУ	Америк нэгдсэн улс
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
БОАЖНХЯ	Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэгчид
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
КНХ	Компанийн нийгмийн хариуцлага
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОУ	Олон улс
ОУБ	Олон улсын байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОУГХАН	Олон улсын гадаад хамтын ажиллагааны нийгэмлэг
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨААН	Төрийн өмчит аж ахуй нэгж
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
УИХ	Улсын их хурал
УУЯ	Уул уурхайн яам
ҮАСДК	Үйл ажиллагааны сайн дурын кодекс

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Компанийн нийгмийн хариуцлагын ач холбогдлын үнэлгээ
- Хүснэгт 2. Зөрчлийн өртгийг бий болгож буй хүчин зүйлс
- Хүснэгт 3. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл (тэрбум.төг)
- Хүснэгт 3. Хамгийн чухал хамааралтай ХУУ-н санаачилгуудын давуу ба сул тал
- Хүснэгт 4. Хариуцлагатай уул уурхайн санаачилгуудын харьцуулалт.
- Хүснэгт 5. МХЕГ-ын хяналтын хуудасны хамрах хүрээ, шаардлагуудын харьцуулалт.
- Хүснэгт 6. МХЕГ-ын хяналтын хуудасны нийцлийн болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн харьцаа.

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Санаачилгуудын хэлбэр
- Зураг 2. ХУУ-н Монгол Улсын туршлага (оны дарааллаар)
- Зураг 2. Уул уурхайн үйл ажиллагаанаас гарах сөрөг үр нөлөө
- Зураг 3. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан төсвийн хэлбэрүүд (2010-2012)
- Зураг 4. ХУУ-н сайн туршлагуудыг дэлхийн газар зүйн байршлаар
- Зураг 5. ХУУ-г үнэлэх дараалал

ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

- График 1. “Уул уурхайн ачаар төрийн төсөв нилээн нэмэгдсэн. Төсвийн зарцуулалтын талаар та ямар бодолтой байна вэ”
- График 2. “Таны бодлоор стратегийн ордуудын хувьд Монголын болон гадаадын хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа ямар байх ёстой вэ”
- График 3. “Монголын талын эзэмшил ямар байх ёстой вэ”
- График 4. Компанийн удирдлага, ажилчдын нийгмийн хариуцлагатай ажилд өгсөн ач холбогдлын үнэлгээ
- График 5. Иргэд, ЖДҮ эрхлэгчдийн нийгмийн хариуцлагатай ажилд өгсөн ач холбогдлын үнэлгээ
- График 6. Нутгийн иргэд уул уурхайн ашиг шимийг жигд хүртдэг эсэх
- График 7. Уул уурхайн үйл ажиллагааны ашиг шимийг хэн хүртдэг вэ?
- График 8. Сумын удирдлагууд уурхайн компанитай харилцахдаа нутгийн иргэдийн эрх ашгийн төлөө үр дүнтэй хамтран ажилладаг эсэх
- График 9. Иргэний нийгмийн байгууллагууд уурхайтай харилцахдаа нутгийн иргэдийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадах эсэх
- График 10. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан төсвийн хэмжээ ба салбар (2010-2012)
- График 11. Компани ба орон нутгийн иргэдийн хооронд үүсдэг зөрчлийн шалтгаанууд
- График 12. Уул уурхайн үе шат ба зөрчлийн тоо хэмжээ
- График 13. Зөрчлүүдийн илрэл (Зөрчлүүд хэрхэн илэрдэг вэ)
- График 14. Хөрөнгө оруулалт ба Төсөв бүрдүүлэлтийн хэмжээ (сая.төг)
- График 15. ДНБ болон АҮ-ийн нийт үйлдвэрлэлд уул уурхайн салбарын эзлэх хувь
- График 16. Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ (мян.хүн)
- График 17. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо
- График 18. Нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь
- График 19. Хариуцлагатай уул уурхайн хамрах хүрээний хамгийн их иш татагдсан байдал

ӨМНӨТГӨЛ

Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь НҮБХХ-ийн Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал төсөлтэй хамтран уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, нийгэм ба эдийн засгийн эрсдлээс сэргийлж, хүний эрхийг хангах, орон нутгийн иргэд цаашлаад улсад бий болох өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд хамтран ажиллаж байна.

Энэ хүрээнд уул уурхайн салбарт ажиллаж байгаа компаниудыг хариуцлагатай ажиллахад нь туслах зорилгоор “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал”-ыг боловсруулахад хамтран ажиллалаа.

Энэхүү жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал нь зөвхөн уул уурхайн компаниудыг сайн засаглалаар хүний эрх, аюулгүй байдлыг хангаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, орон нутгийн хөгжлийг дэмжиж тухайн компанийн эрсдлийн менежментийг сайжруулан, урт хугацаанд тогтвортой ашигтай ажиллахад туслаад зогсохгүй салбарын бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарт салбарын бодлого, хөтөлбөр, стандартыг үнэлж илүү сайжруулахад ашиглагдах олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН
ХЯНАЛТЫНГАЗРЫН ДАРГА** **Н.БАТБАЯР**

ОРШИЛ

Уул уурхайн салбар нь хэдийгээр Монгол Улсад шинэ салбар биш боловч 1992 онд ардчилсан үндсэн хуультай болж иргэдийн оролцоотой бодлого боловсруулах, хяналт тавих, хэрэгжүүлэх болсноор уул уурхайг байгаль болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатай, эдийн засаг, нийгмийн амьдралд бодит өгөөжтэй байхуйцаар ашиглах нь бидэнд шинэ тутамд тулгарч буй бэрхшээл болоод байгаа төдийгүй дэлхий нийтийн хүн амын хэт өсөлтийг дагасан хэрэглээний хурдацтай өсөлтийг хангах түүхий эдийн олборлолт сүүлийн 20 жилийн дотор асар хурдацтай өсөн нэмэгдэж тэр хэрээрээ хариуцлагатай уул уурхай, уул уурхайн тогтвортой хөгжилтэй холбоотой судалгаа ач холбогдолтой болж байна.

Хариуцлагатай уул уурхайг бүрэн илэрхийлэхүйц судалгааны ажил элбэг биш боловч хариуцлагатай уул уурхайн чухал бүрэлдэхүүн хэсэг болох уул уурхайн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах чиглэлд хийгдсэн судалгааны ажил цөөнгүй байна. Иргэд болон төрийн байгууллага, төрийн өмчит уул уурхайн компаниуд хариуцлагатай уул уурхайн талаарх мэдлэг, мэдээлэл муутай, компанийн нийгмийн хариуцлагыг компанийн хувьд зардлыг ихэсгэдэг, сайн дурын үндсэн дээр хийгддэг зүйл гэдэг ойлголттой байдгийг судалгааны явцад олж мэдсэн. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх Монгол Улсын болон олон улсын сайн жишиг, шаардлагууд (баримт бичгүүд)-ыг харьцуулах замаар хариуцлагатай уул уурхайн хамрах хүрээ, шаардлагуудыг буюу уурхайн нөлөөллийг бүлэглэн ангилах мөн энэхүү судалгаагаар компаниуд яагаад хариуцлагатай байх шаардлагатай талаарх зөв ойлголтыг бий болгох, хариуцлагыг үнэлж, сайжруулах боломжит аргачлалыг боловсруулна.

Түлхүүр үг: *Хариуцлагатай уул уурхай, байгаль орчны засаглал, уул уурхайн нийгмийн хариуцлага, олборлох салбарын тогтвортой хөгжил, уул уурхайн тогтвортой хөгжил, олборлох салбарын засаглал, байгалийн баялгийн засаглал, уул уурхайн байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэлгээ.*

ТАЛАРХАЛ

НҮБХХ-ийн Байгалийн Нөөцийн Тогтвортой Удирдлагыг Хангах Байгаль Орчны Засаглал Төслөөс “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлэх аргачлал” боловсруулах судалгааны ажилд өөрийн мэдлэг, чадвараар харамгүй тусалсан Эдийн засагч Д.Түвшинбат, судлаач Т.Самданжигмэд (байгаль орчны хамгаалал), Си Би Эм ХХК-ийн ахлах геологич Т.Говьдэлгэр, SGS ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтсийн дарга Д.Ариунболд, судлаач Л.Энхжаргал (ХАБЭМ), OSHMI ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Оюунтөгс, Дэлхийн Банкны ОҮИТБС-ын Ажлын албаны харилцааны менежер Б.Дэлгэрмаа болон мэдээлэл цуглуулах ажилд гүн туслалцаа үзүүлж, үнэтэй цагаа гарган зөвлөгөө өгсөн МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын дарга Н.Батбаяр, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Энхгэрэл, Ашигт малтмал, газрын тосны газрын Хүнд үйлдвэр, техник технологийн хэлтсийн дарга Г.Тамир болон өөрсдийн туршлагаасаа хуваалцаж, гишүүн байгууллагуудаас санал авахад дэмжиж, зөвлөсөн Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алагаа гүйцэтгэх захирал Д.Энхболд нарт талархалаа илэрхийлье.

Мөн НҮБХХ-ийн төслийн удирдагч Л.Бархас, судалгааны бүхий л цаг хугацаанд удирдан чиглүүлж, санал зөвлөмж өгсөн төслийн үндэсний зөвлөх Д.Жавхланболд нарт талархал илэрхийлье.

Судалгааны явцад дэмжлэг үзүүлж, зохих мэдээллээр ханган, санал зөвлөмж өгч байсан иргэний нийгмийн байгууллага болон компаниудын холбогдох мэргэжилтнүүдэд дахин дахин талархалаа илэрхийлье.

Судалгааны ажлын зорилго, ач холбогдол

Уул уурхайн салбарын хариуцлагыг бүрэн дүүрэн илэрхийлэхүйц зөв системтэй ойлголтыг гаргах, зарчим, хамрах хүрээг тодорхойлох, хариуцлагын түвшинг хэмжих боломжит шаардлагууд, үзүүлэлтийг боловсруулах. Ингэснээр олборлох салбарын хариуцлагыг бүрэн дүүрэн илэрхийлэхүйц уурхайн нөлөөллийг бүгдийг хамарсан хамрах хүрээ, шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, бөгөөд ингэснээр төрийн болон төрийн бус байгууллага олборлох салбарын үйл ажиллагааг сайжруулахдаа хэрэглэх шаардлагуудыг гаргаж, түүний дагуу хянаж сайжруулснаар эрдэс баялгийн салбар нь зөв замаар хөгжиж байгаа эсэхэд хяналт тавих, сайжирч эсвэл муудаж байгааг харуулах боломж бүрдэнэ.

Сэдвийн судлагдсан байдал

Хариуцлагатай уул уурхай нь зөвхөн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахтай холбоотой бус цогц байдлаар тодорхойлогдоход 1983 оны Брундландын тайлан гэдгээрээ алдартай “Бидний хамтын ирээдүй” нэртэй Байгаль орчин ба Хөгжлийн Дэлхийн Хорооны тайлан, илтгэлд “Тогтвортой хөгжил”-ийг тодорхойлж өгсөн нь том хувь нэмэр болсон¹. Тогтвортой хөгжил гэдэг нь “Хойч ирээдүй үеийнхээ хэрэгцээгээ хангах чадамжид сөргөөр нөлөөлөлгүйгээр өнөөгийн хэрэгцээгээ хангах”-ыг хэлнэ² гэж дээрх баримт бичигт туссан байдаг.

21 дүгээр зууны эхээр олон улсад тогтвортой хөгжлийг хангах засаглалын тогтолцоог бий болгох санаачилгууд гарч эхэлсэн. НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр болон Дэлхийн банк хамтарч 2002 онд Өмнөд Африкийн нийслэл Иохансбург хотноо “Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалт”-ыг зохион байгуулсан. Энэхүү уулзалт нь олон талын оролцоог хангасан байсан бөгөөд төрийн биш оролцогчдод, ялангуяа ТББ, үндэстэн дамнасан компаниуд тогтвортой хөгжлийг хангах гол оролцогчид гэдгээ ухамсарлаж санаачилгатай оролцогчид болсон.³ Үүнээс өмнө ашигт малтмалын үнийн бууралт, уурхайн хаалтын муу туршлагатай холбоотой олборлох салбарт хямрал бий болж олон

¹ Hevina S.Dashwood 2012. The rise of global corporate social responsibility. 2012. Cambridge University Press. 10 дахь тал

² Harlem Brundtland. Gro. “Our common future” World Commission on Environment and Development. 1983. Oslo.

³ Hevina S.Dashwood 2012. The rise of global corporate social responsibility. 2012. Cambridge University Press. 5 дахь тал

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

нийтийн зүгээс итгэл үзүүлэхгүй байх хандлага үүссэн байсантай холбоотой эдийн засгийн үр өгөөж, хүний эрх, байгаль орчны эрсдлүүдийг чухалчилан үзэх болсоноор уурхайг хариуцлагатайгаар эрхлэхэд шаардагдах шалгуур үзүүлэлтүүд илүү боловсронгуй болж хөгжсөн байдаг.

Судалгааны арга зүй

НҮБ-аас гаргасан тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, хариуцлагатай уул уурхайтай холбоотой олон улсын стандарт баримт бичгүүд, Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлогын баримт бичиг болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд дээр тулгуурлан олборлох салбарын хариуцлагыг тодорхойлох *тайлбарлагч хувьсагчийг* гаргах. Монгол Улсад хэрэгжиж буй төсөл, ОУБ болон бусад улс орны уул уурхайг зохистой хөгжүүлэх санаачилгуудыг харьцуулж *хянагч хувьсагчийг* олох замаар компанийн үйл ажиллагааны нөлөөлөл, экологийн ул мөрийг бүгдийг багтаасан хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг цогц болгох. Судалгаанд мэдээлэл цуглуулалт, ажиглалтын аргаас гадна харьцуулсан дүн шинжилгээ хийх аргыг голчлон ашиглаж, мэдээллийн дутагдалтай байдлыг ярилцлагын аргаар нөхсөн.

Хариуцлагатай уул уурхайн шаардлагуудыг боловсруулахад дараахь 7 зарчмыг баримтласан. Үүнд:

- Уурхайн нөлөөллийг бүгдийг хамарсан байх.
- Компанийн урт хугацааны үйл ажиллагаанд эерэг үр дүн үзүүлэхүйц байх.
- Шаардагууд нь системийн хувьд бие биенээ дэмжин ажилладаг байх.
- Олон улсын сайн туршлагыг хөрсөнд нь буулган тайлбарлаж эерэг соёлыг үлдээхүйц байх.
- Уул уурхайн салбарт ашиглагдаж байгаа одоогийн тогтолцоог аль болох ашиглаж дутуу орон зайг нөхдөг байх.
- Товч тодорхой, энгийн ойгомжтой байх.
- Хэрэглэхэд хялбар, нэгтгэн дүгнэх боломжтой байх.

Үнэлгээний аргачлалыг боловсруулахад менежментийн гүйцэтгэлийг хянах удирдлагын хяналтын аргуудыг ашиглах нь одоогийн МХЕГ-ийн нийцлийн үнэлгээг илүү сайжруулж хэрэгжилтээр эерэг үр дүнг гаргах боломжтой гэж үзсэн.

Сэдвийн хамрах хүрээ

Судалгаа нь олборлох салбарын хариуцлага, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн бүхий л дотоодын болон олон улсын жишиг туршлага, санаачилгын хүрээнд хийгдэнэ. Санаачилга гэдэг нь стандарт, удирдамж, зөвлөмж, хөтөлбөр, зарчим, сертификат, гарын авлага, аргачлал, тайлан зэрэг баримт бичгүүдийг хамруулан үзнэ. Хугацааны хувьд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал гарсан 1987 оноос 2017 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд гаргасан баримт бичгүүдээр судалгааны цаг хугацааны хүрээ хязгаарлагдана. Мөн газрын тос, хий болон бичил уурхайгаас бусад олборлох салбарын компаниудад хэрэглэгдэнэ.

Судалгааны хязгаарлагдмал байдал ба хүндрэл бэрхшээл

Олборлох салбарт хийгдсэн судалгааны хомс байдал болон мэдээллийн нэгдсэн сангүй, харьцуулалт хийх жишиг бусад улс орнуудад бодитоор нэвтрээгүй зэрэг нь судалгааны гол бэрхшээл бөгөөд харьцуулалт хийх баримт бичгүүдийн дийлэнх нь монгол хэл дээр орчуулагдаагүйн улмаас баримт бичгийн утгыг бүрэн дүүрэн ойлгоход хугацаа их зарцуулах мөн тус салбар дахь ажлын туршлага багатай зэрэг нь судалгааны удаах бэрхшээл байх магадлалтай боловч тухайн салбарын мэргэшсэн мэргэжилтнүүд, оролцогчидтой хамтран боловсруулах бүрэн боломжтой.

Монгол Улсын ашигт малтмалын тухай хуулиар олборлох салбарын компаниудын чадамжийн ангилал, зэрэглэл байдаггүй байгалийн нөөцийн эрэл хайгуул хийх, олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхлэж байгаа бүх компанийг хамруулан үздэг нь шаардлагуудыг боловсруулахад хэт ерөнхий гарах магадлалтай байсан тул асуулга, ярилцлагын аргаар илүү нарийвчилан боловсруулсан.

I БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Уул уурхайн салбарын статистик үзүүлэлтүүд

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг уул уурхайн салбараас салган ойлгохын аргагүй. Экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн үйлдвэрлэлийг Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон. 2009-2012 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх уул уурхайн салбарын хувь хэмжээний өсөлт 3.6-8.9 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн дэх уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт 9.7-35.4 хувь, экспорт дахь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт 61.4-73 хувь болж нэмэгджээ. Монгол Улсын ДНБ 2012 онд 12.3 хувиар өссөн ба үүний 8.9 пунктыг уул уурхайн салбар дангаараа эзэлж байв.

2015 онд дэлхийн эрдэс түүхий эдийн зах зээлийн үнийн уналт үргэлжилсэн хэвээр байсан ч Монгол Улсын хувьд голлох нэр төрлийн ашигт малтмалын олборлолт, экспортын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс бууралгүй, төлөвлөсөн хэмжээндээ хүрснээр улс орны эдийн засагт зохих хувь нэмэр оруулж чадсан. Харин 2016 онд дэлхийн зах зээл дээр коксжих нүүрс, зэс, цайрын баяжмал зэрэг уул уурайн гол нэр төрлийн ашигт малтмалын үнэ бага зэргийн өсөлтийн улмаас Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ өссөн байна.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ


Хүснэгт 3. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл (тэрбум.төг) ⁴

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
ДНБ	9756,6	13173	16688,4	19174,2	22227,1	23166,8	23886,4
Уул уурхай, олборлолт	2102,2	2536,2	2742,8	2849,4	3661,0	3867,7	3984,8
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл	4987,0	6185,6	5723,6	7651,7	9299,6	8714,4	9927,1
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	3097,0	3752,3	3839,7	5217,4	6388,9	5858,0	7884,7

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn

Тухайлбал, 2016 онд уул уурхайн салбар нь ДНБ-ий 16.7 хувь, төсвийн орлогын 19.6 хувь, 2017 оны 1 дүгээр сарын байдлаар, аж үйлдвэрийн салбарын нийт үйдвэрлэлийн 79.4 хувь, экспортын орлогын 79.3 хувийг дангаар бүрдүүлсэн байна.

График 14. Хөрөнгө оруулалт ба төсөв бүрдүүлэлтийн хэмжээ (сая.төг)



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.

⁴ Уул уурхайн салбарын дэлгэрэнгүй статистик мэдээлэл. 2017. Ашигт малтмал, газрын тосны газар.

График 15. ДНБ болон АҮ-ийн нийт үйлдвэрлэлд уул уурхайн салбарын эзлэх хувь⁵




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn

2016 оны байдлаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд 80 төрлийн ашигт малтмалын 1,170 орд, 8000 орчим илрэл тэмдэглэгджээ. 2015 оны байдлаар ашиглалтын 1,494 тусгай зөвшөөрөл олгогдсоны 33.5 хувь нь алт, 18.7 хувь нь нүүрс, 20.7 хувь нь түгээмэл тархацтай ашигт малтмал, 11.2 хувь нь жонш, 4.8 хувь нь төмөр, 2.1 хувь нь гянтболд, 9.0 хувь бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байна.

⁵ Уул уурхайн салбарын дэлгэрэнгүй статистик мэдээлэл. 2017. Ашигт малтмал, газрын тосны газар.

График 16. Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ (мян.хүн)



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn

График 16-т нийт хөдөлмөр эрхлэлтийн 4.4 хувийг уул уурхайн салбар эзэлж байгаа нь уул уурхайн салбарын хөрөнгийн урсгал бодит секторт үлдэхгүй байх магадлалтайг харуулна.

График 17, 18-д Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.9 %-д хайгуулийн, 7.7%-д ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байх бөгөөд нийт тусгай зөвшөөрлийн олголт 2009 онд эрчимтэй өсөж 2014 оноос буурсан боловч 2016 оноос хайгуулын тусгай зөвшөөрөл олголт нилээд эрчимжиж ашиглалтын тусгай зөвшөөрөл олголт нэмэгдсэн байна.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

График 17. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn

График 18. Нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

Уул уурхайн татварын хуваарилалт:

№	Татварын төрөл	Улс	Аймаг	Сум
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	+		
2	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	+		
3	Авто тээврийн болон өөрөө явах хэрэгслийн албан татвар		+	
4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	+		
5	Гаалийн албан татвар	+		
6	Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	+		
7	Газрын төлбөр		+	
8	Ус бохирдуулсны төлбөр	+		
9	Агаарын бохирдлын төлбөр	+		
10	Ус ашигласны төлбөр		+	+
11	Хувь хүний орлогын албан татвар		+	+
12	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж			+
13	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр			+
14	Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр			+
15	Хог хаягдлын үйлчилгээний хураамж			+
16	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	+		
17	Ажилчны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	+		
	Нийт дүн			

1.2 Уул уурхайн салбарын эрх зүйн орчин

Өнөөгийн байдлаар манайд КНХ-ын цогц асуудлыг багтаасан эрх зүйн зохицуулалт байхгүй ч уул уурхайн нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал нь Хөдөлмөрийн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Компанийн тухай хууль, Татварын хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль зэрэг хуулиуд болон Засгийн газар, түүний хэрэгжүүлэгч агентлагуудын холбогдох тогтоол, шийдвэр, бусад холбогдох дүрэм журам, стандартад тусгагдан зохицуулагдаж байна.

Хариуцлагатай уул уурхайг монголд хэрэгжүүлэхэд УИХ, Засгийн газрын зүгээс дэмжин, бодлого төлөвлөлтийн олон баримт бичигт энэ асуудлыг тусгасан байдаг. Үүнд: Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалын 3.2.1.3-д “Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна”, 3.2.4.1-д “Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна” гэж заасан байна. Мөн Монгол Улсын Улсын Их Хурлын “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.3.1-д “... байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах”, 3.3.3-д “Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжинэ” гэж мөн 2012-2016 оны Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд 2 ба 3.2-д “Хариуцлагатай ил тод уул уурхайг төлөвшүүлнэ” гээд “Уул уурхайн компаниудын хариуцлагын шалгуур үзүүлэлт, стандартыг шинэчлэн боловсруулж, хариуцлагын зэрэглэлийг тогтоон жил бүр олон нийтэд мэдээлнэ” гэж тус тус заасан. 2016-2020 оны дунд хугацааны төлөвлөгөөнд “Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэж тус тус тусгасан. Хэдийгээр бодлогын баримт бичигт тусгагдсан Засгийн газрын

үйл ажиллгааны хөтөлбөрт тусгагдсан боловч хэрэгжилт удаашралтай төрийн байгууллагын зүгээс санал, санаачилга муутай, төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд дээр дурдсан эрх зүйн голлох баримт бичигт тодорхойлон заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн сайжруулах, хариуцлагатай уул уурхайн стандартыг боловсруулан батлуулах, уул уурхайн компаниудын хариуцлагын түвшинг нь тогтоож, үүний үр дүнд сургалтыг явуулах, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн зорилго тавигдаж байна.

Өнөөдөр уул уурхайн салбарт 30 орчим хууль, 40 гаруй журам, дүрэм, заавар үйлчилж байна. Салбарын хамгийн анхны эрх зүйн акт нь 1913 онд Богд хааны баталсан Олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм байсан бол хамгийн сүүлийнх нь 2015 онд УИХ-аас нэмэлт, өөрчлөлт оруулсан Ашигт малтмалын тухай хууль (АМТХ) юм. Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд шинэчлэн баталснаас хойш өнөөг хүртэл 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуульд 2008 онд 1, 2009 онд 3, 2010 онд 2, 2011 онд 2, 2012 онд 1, 2013 онд 1, 2014 онд 4, 2015 онд 4 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Ингэж 18 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь салбарын хууль эрх зүйн орчин тогтвортой биш байгааг харуулж байна.⁶ Монгол Улсын уул уурхайн салбарт дараах гол хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- Үндсэн Хууль (1992),
- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014),
- Ашигт малтмалын тухай хууль (2006),
- Газрын хэвлийн тухай хууль (1988),
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009),
- Байгаль орчны багц хуулиуд (1995),
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001),
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль (2013),
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994),

⁶ Монголын уул уурхайн салбарын авилгын эрсдлийн үнэлгээ. Хараат бус судалгааны хүрээлэн. 2016

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

- Газрын тухай хууль (2002),
- Хөрөнгө оруулалтын тухай хууль (2013),
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014),
- Татварын багц хууль (2008),
- Цөмийн энергийн тухай хууль (2009) гэх мэт.

Авлигаас урьдчилан сэргийлэх, нутгийн удирдлагатай холбоотой дараах хуулиуд уул уурхайн салбарт хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

- Авлигын эсрэг хууль (2006),
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (2012),
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (2011),
- Шилэн дансны тухай хууль (2014),
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006),
- Төсвийн тухай хууль (2011),
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014) хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

2015 оны 5 дугаар сарын 21-нд батлагдсан “Төсвийн тухай хууль”-ийн 60 дугаар зүйлийн 60.5-60.10, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт ашигт малтмалын төлбөрийн орлоготой холбоотой нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Ялангуяа энэхүү нэмэлт өөрчлөлтөд улсын төсвөөс Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд, Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд тус тус олгохоор заасан. Энэхүү нэмэлт өөрчлөлт бүхий хуулийг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. 43.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-

аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. 44.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна гэсэн заалтууд хариуцлагатай уул уурхайг эрхлэхэд чиглэсэн төрийн гол зохицуулалт юм. Мөн олон нийтийн оролцоог хангах хуулийн гол заалт нь тус хуулийн 19.4-т Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ хэмээсэн байдаг. 25.10-т Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно гэж заасан байдаг нь төрийн өмчит уул уурхайн байгууллагад орон нутгийн иргэдэд КНХ-ын хүрээнд хамтран ажиллах боломжийг хязгаарлаж, нягтлан бодох бүртгэлийн стандартыг зөрчихөд хүргэдэг. Энэ нь цаашлаад тухайн мөнгөний зарцуулалтыг хяналтгүй болгож шаардлагатай хүндээ хүрэхгүй байх эрсдлийг бий болгож байна. 2011 онд Монголын уул уурхайн үндэсний ассоциациас Ашигт малтмалын тухай хуульд судалгаа хийхэд:

- Ашигт малтмалын тухай хуультай шууд холбогдох хууль - 52
- УИХ-ын тогтоол - 2
- Засгийн газрын тогтоол - 16
- Сайдын тушаал - 23
- Засгийн газрын агентлагаас гаргасан эрх зүйн акт - 26
- Ашигт малтмалын тухай хуультай холбоотой Улсын дээд шүүхийн тогтоол - 1
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр - 1
- Шүүхийн шийдвэр - 198 байдгийг тогтоож, хуулийн давхардал нийт 52, Зөрчил 36, хуулийн хийдэл 22 байна гэж дүгнэсэн. АМТХ-ийн хэрэгжилттэй холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхээр шийдэгдсэн уг хуультай холбоотой маргааны тоо эрс нэмэгдсэн. Захиргааны хэргийн

шүүх байгуулагдсан 2004 оноос хойш 11 жилийн хугацаанд АМТХ-тай холбоотой 569 хэрэг маргааныг хянан шийдвэрлэжээ. Шийдсэн хэргийн тоо 2007 оноос нэмэгдэж, 2012 онд дээд цэгтээ хүрээд, одоогоор улмаар уул уурхайн салбарын уналтыг дагаж багасчээ.⁷

1.3 Уул уурхайн авлигын эрсдлийн үнэлгээ

Уул уурхайн салбарт томоохон хэмжээний түрээс, их хэмжээний хөрөнгө оруулалт, нарийн төвөгтэй гэрээ хэлэлцээр хийгддэг тул авилгын өндөр эрсдэлтэй салбарт тооцогддог. Дэлхийн улс орнуудын авилгын түвшинг харьцуулан үнэлдэг “Транспаренси Интернэйшнл” ОУБ-ын 2014 оны Авлигын индексийн судалгаанд нийт 168 орон хамрагдсанаас Монгол Улс 39 оноотойгоор 72 дугаар байранд жагссан.⁸

“Монголын уул уурхайн салбарын авилгын эрсдлийн үнэлгээ”⁹-гээр хайгуулын тусгай зөвшөөрөл авахаас эхлээд нөхөн сэргээлт хийх хүртэл уул уурхайн амьдралын мөчлөгт тохиолдох авилгын эрсдлийн үнэлгээг хийхэд 15 багц эрсдэл байхаар гаргасан байна. Үүнд:

1. Өргөдлийн журмаар тусгай зөвшөөрөл авах үе шатанд шийдвэр гаргах үйл явцтай холбоотой авлигын эрсдэл бодитой байна.
2. Сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой авлигын эрсдэл байна.
3. Хайгуулын шатанд орон нутгийн Засаг дарга, ИТХ-аас санал авахтай холбоотой авлигын эрсдэл бодитой байна.
4. Ашигт малтмалын нөөцийн тооцоо, үнэлгээний дүгнэлтэд нөлөөлөхтэй холбоотой авлигын эрсдэл байна.
5. ТЭЗҮ-гийн дүгнэлтийг хурдан шуурхай батлуулахтай холбоотой авлигын эрсдэл үүсч байна.
6. Бүтээн байгуулалтын зөвшөөрлүүдийг богино хугацаанд авахтай холбоотой авлигын эрсдэл байна.
7. Уул уурхайн компанийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл.

⁷ Монголын уул уурхайн салбарын авилгын эрсдлийн үнэлгээ. Хараат бус судалгааны хүрээлэн. 2016

⁸ <http://www.transparency.org/cpi2015>

⁹ Монголын уул уурхайн салбарын авилгын эрсдлийн үнэлгээ. Хараат бус судалгааны хүрээлэн. 2016

8. Ялангуяа мэргэжлийн хяналтын байгууллага, Засаг дарга нараас хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл байна.
9. Компаниудаас орон нутагт үзүүлж байгаа хандив, тусламжтай холбоотой авлигын эрсдэл нийтлэг байна.
10. Орон нутгийн иргэд уул уурхайн компанийн хоорондын зөрчилтэй холбоотой авлигын эрсдэл.
11. Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай холбоотой авлигын эрсдэл.
12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг батлуулахтай холбоотой үүсдэг авлигын эрсдэл.
13. Ашигт малтмалын борлуулалттай холбоотой авлигын эрсдэл. Борлуулалттай холбоотой татвар, тайлан, гаальтай холбоотой авлигын багц эрсдэл нуугдмал мөртлөө түгээмэл гарч байгааг зөвхөн татвараар жишээлэн тус тайланд оруулав. Цаашид эдгээрийг нарийвчлан судлахыг үнэлгээний баг санал болгож байна.
14. Уурхайг хаах шийдвэр гаргуулахтай холбоотой авлигын эрсдэл.
15. Уул уурхайн хаалттай холбоотой эрх зүйн зохицуулалт дутуугаас үүдэлтэй авлигын эрсдэл.
16. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөтэй холбоотой авлигын эрсдэл.

Эдгээр эрсдэлүүдийн дийлэнх нь хууль эрх зүйн орчны дутуу зохицуулалттай холбоотой байх бөгөөд салбарын ерөнхий хуульд туссан ч нарийвчилсан журмууд хангалтгүй, хариуцлагатай уул уурхайн тулгуур зарчим болох иргэдийн оролцоог хангасан зохицуулалт хангалтгүй байгааг харуулсан байна.

II БҮЛЭГ. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

1.1 Хариуцлагын тухай ойлголт ба түүний мөн чанар

Хариуцлагыг монгол хэлний товч тайлбар тольд “Хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцаж биедээ хүлээсэн нь”¹⁰, Кембрижийн тайлбар тольд “something that it is your job or duty to deal with” буюу “таны хариуцаж хийх ажил эсвэл таны шийдэх, учрыг нь олох ёстой үүрэг” харин англи хэлний цахим тайлбар тольд “the state or fact of being responsible, answerable, or accountable for something within one's power, control, or management” буюу эрх мэдэл, удирдлагыг хэрэгжүүлснээс гарах үр дүнг тайлагнах, хариулах, хариуцах чадвартай байх гэсэн байна. Төслийн менежментийн институциас гаргасан гарын авлагад “Responsibility is our duty to take ownership for the decisions we make or fail to make, the actions we take or fail to take, and the consequences that result” буюу “Хариуцлага гэдэг бол гаргасан аливаа шийдвэр (сонголт) болон түүнээс гарах үр дүндээ хариуцлага хүлээх үүрэг” гэж тодорхойлсон.

Дээрх тодорхойлолтуудаас харахад хариуцлага гэдэг бол хэн нэгэн шийдвэр гаргахаар сонголт хийж, хийсэн сонголтынхоо үр дагаврыг хариуцах үүрэг юм байна. Үүрэг (duty)-ийг responsibility буюу хариуцлага ба obligation буюу албадлага гэж хоёр ангилж үздэг.¹¹ Хариуцлага нь хувь хүний морал, ёс зүйгээс хамаардаг тул сайн дурын үндсэн дээр хийгдэнэ харин албадлага нь нийтийн сайн сайхны төлөө сайн дурын бус хэлбэртэй байна.¹²

Хариуцлагын тухай ойлголт нь тийм ч сайн тодорхойлогдоогүй бөгөөд анх улс төрийн хүрээнд хэрэглэж эхэлсэн. (Paul Ricoerit, 2000 мөн McKeon, 1957) Улс төрийн хүрээнд нийтийн өмнө хариуцлага хүлээх төлөөллийн засгийн газрын зарчимтай холбоотой яригдаж байсан. 19 дүгээр зууны дундуур Жон Стуард Милл хариуцлагыг хүний чөлөөт хүсэл “free will”-тэй холбон тайлбарлахдаа төлөөллийн засгийн газрын зарчмыг гаргах зорилгоор бичсэн. 19 дүгээр зууны сүүлээр Макс Вебер улс төрчийн хариуцлагын ёс зүйн санааг дэвшүүлж улстөрчийн хийсэн үйлдлээс гарах үр дагавартай холбон тайлбарласан бол 20 дугаар зуунд хариуцлагын тухай ойлголтыг чөлөөт хүсэл, детерминизмтэй холбон тайлбарлах болсон бөгөөд “Хариуцлагатай байна гэдэг

¹⁰ Я.Цэвэл. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966. 666 даь тал.

¹¹ Carol W. Lewis., Stuart C. Gilman. The Etchics Challenge in Public Service. A Problem Solving Guide. 2012. 34 дэхь тал.

¹² Мөн тэнд

нь юу вэ” “Юунд хариуцлагатай байх ёстой вэ” гэсэн асуултуудад хариулахыг зорьсон. Неолиберал онолын хувьд хариуцлага нь хүний “free will” буюу чөлөөт хүсэлтэй холбогдон тайлбарлагддаг.

Харин 21 дүгээр зуунд хариуцлагын тухай ойлголт нь улам нарийвчлан судлагдаж хамтын хариуцлагатай (Collective responsibility and Shared responsibility) холбоотой асуултуудад хариулт өгөхийг зорьж байна. Хамтын хариуцлага нь аливаа байгууллага, компанид нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн стратеги, төлөвлөгөөгөөр илэрдэг.

Нийгмийн хариуцлага гэдэг нь байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаа, нөлөөлөл нь нийгэм, хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж буй хэмжүүр, үзүүлэлтүүдийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ¹³. КНХ гэдэг нь байгууллага нийгэм болон, эдийн засагт үзүүлж буй өөрийн нөлөөллөөс гарах үр дагаврыг хариуцахыг хэлнэ. КНХ-ийг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг гэдэг ойлголт нь ташаа ойлголт бөгөөд хэрвээ сайн дурын гэж харах юм бол хандивын үйл ажиллагаа болж компанийн хувьд хандив үзүүлэх шалтгаанаа сонгох боломжтой гэж ойлгогдоно. Эдийн засгийн салбарын Нобелийн шагналтан Милтон Фридман хэлэхдээ “Компанийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах нь ашиг орлогыг хамгийн их байлгаж хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд компани нь хувь нийлүүлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд хуулийг биелүүлэхийн сацуу улсаас гаргасан хүний хөдөлмөр, хүний эрх, байгаль орчныг хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлэх нийгмийн норм, үнэт зүйлийг дагах болно” гэсэн байна.¹⁴ Нийгмийн хариуцлагын тухай нарийн тодорхойлсон тодорхойлолт байхгүй байна. Менежментийн салбарт нийгмийн хариуцлагын дараачийн хөгжлийн шатыг Үнэ цэнээ хуваалцах стратеги (Shared value strategy) гэж үзэж байгаа бөгөөд энэ нь нийгмийн хариуцлагын стратегиас ашиг орлогот түлхүү суурилсан гэдгээрээ ялгардаг. Өөрөөр хэлбэл нийгмийн хариуцлага нь байгууллагын эрсдэлд суурилсан зардлыг бууруулахад чиглэсэн бол Үнэ цэнээ хуваалцах стратеги нь байгууллагад тулгарах бэрхшээлийг боломж болгоход чиглэгддэг.

Уул уурхайг зөв ашиглана гэдэг нь товчхондоо тухайн уурхайг ашигласнаар улс орны хөгжилд нь нэмэртэй, ард түмний амьдралд тустай, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хохиролгүй байхыг хэлэх ба уул уурхайг төлөвлөж эхлэхээс

¹³ Компанийн нийгмийн хариуцлагын удирдамж MNS ISO 26000:2012

¹⁴ Hevina S.Dashwood 2012. The rise of global corporate social responsibility. 2012. Cambridge University Press. 9 дэхь тал

авхуулаад дуусах хүртэл хийгдэх олон талын цогц арга хэмжээ. Эдгээр нийт арга хэмжээг олон улсын хэмжээнд “Responsible Mining” гэж нэрлэсэн бөгөөд “Хариуцлагатай уул уурхай” гэж нэрлэж байна. Хариуцлагатай уул уурхайн баталгаажуулалтын санаачилгаас тодорхойлсноор нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдийн хүсэл сонирхол болон хүний эрхийг хүндэтгэх, аюулгүй, эрүүл мэндэд хоргүй ажлын орчинг бий болгох, байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах болон зөв эерэг өв уламжлал үлдээх гэсэн байна.¹⁵ Хариуцлагатай уул уурхайн сангийн тодорхойлсноор Хариуцлагатай уул уурхай гэдэг нь “Уул уурхайн үйл ажиллагаа тухайн үйлдвэрлэгч орны ард түмэн, орон нутгийн иргэдийн эрх ашиг болон хүрээлэн буй орчныг илтэд хүндэтгэн хамгаалсан байхаас гадна эдийн засгийн хөгжилд нь өргөн хүрээнд, шударгаар болон мэдэгдэхүйц хувь нэмэр оруулахыг хэлнэ”¹⁶ гэсэн байна.

Дээрх тодорхойлолтуудаас харахад аливаа байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэн гарах сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, сэргийлэхийн тулд хийгддэг үйл ажиллагааг хариуцлагатай уул уурхай гэж ойлгож болохоор байна.

2.2 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл ба эрсдэл

Уул уурхайн салбар нь хөгжиж буй орны үндэсний хэмжээнд болон уул уурхайн үйл ажиллагаа¹⁷ явагдаж буй орон нутгийн түвшинд чухал үр нөлөө¹⁸ үзүүлж байна. Энэхүү үр нөлөө нь зөвхөн эерэг үр дагавартай байгаад зогсохгүй олон сөрөг үр дагаврыг бий болгож байна.

¹⁵ IRMA Standart for Responsible Mining IRMA-SDT-001 Draft v2.0, 2016

¹⁶ Responsible mining index draft methodology. Responsible mining foundation. 2016

¹⁷ MINING LIFE CYCLE

¹⁸ MNS ISO 31000:2011-д тодорхойлсоноор үр нөлөө гэдэг нь: Хүлээгдэж буй үр дүн хазайхыг үр нөлөө гэх ба энэ нь эерэг болон/буюу сөрөг байж болно.

Зураг 2. Уул уурхайн үйл ажиллагаанаас гарах сөрөг үр нөлөө



Сөрөг үр дагавар нь ирээдүйд эрсдэл¹⁹-ийг бий болгож байдаг тул уул уурхайн компаниуд өөрийн үйл ажиллагаанаас шалтгаалсан ирээдүйд тохиолдох сөрөг нөлөөлөл буюу эрсдэлийг бууруулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь компанийн нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлого, хариуцлагатай уул уурхайн хөтөлбөр, санаачилгаар илэрдэг. Өөрөөр хэлбэл уул уурхайн компаниуд тогтвортой хөгжлийн дагуу үйл ажиллагаагаа эрхлэх хөдөлгөгч хүчин зүйл нь тухайн компанийн зардлаа бууруулах, урт хугацаанд тогтвортой орлого олох явдал юм.²⁰ Уул уурхайн салбарт тохиолддог зах зээлийн бус эрсдэл (зах зээлийн эрсдэл: түүхий эдийн үнийн өсөлт, уналт, бүтээгдэхүүн борлуулалтын өрсөлдөөн) нь тухайн байгууллагын зардлыг ихэсгэхээс гадна ирээдүйд олох орлогыг бууруулж, ирээдүйд хэрэгжүүлэх бусад төслийн боломжийг бууруулж байдаг.


Монгол Улсын хувьд уул уурхайн үйл ажиллагаанаас гарах үр нөлөөг бүхэлд нь цогц байдлаар судалсан эмпирик судалгааны ажил хомс байх бөгөөд байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах талаас нь судалсан судалгаанууд түлхүү байна. Харин уул уурхайн үйл ажиллагаа иргэдийн нийгмийн амьдралд ямар үр нөлөө үзүүлж буй талаарх хоёрдогч эх үүсвэрийн судалгаа цөөнгүй хийсэн байна. Иргэд уул уурхайн үйл ажиллагааны талаарх хандлагын судалгааг Сант марал судалгааны төвөөс жил бүр хийж байна.

¹⁹ MNS ISO 31000:2011-д тодорхойлсоноор эрсдэл гэдэг нь: Зорилтыг тодорхой бус болгож буй үр нөлөөг хэлдэг.

²⁰ Hevina S.Dashwood 2012. The rise of global corporate social responsibility. 2012. Cambridge University Press. 9 дэхь тал


ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

График 1. “Уул уурхайн ачаар төрийн төсөв нилээн нэмэгдсэн. Төсвийн зарцуулалтын талаар та ямар бодолтой байна вэ”



Эх сурвалж: Нийгэм, эдийн засгийн барометер. Сантмарал судалгааны төв. 2016.

График 2. “Таны бодлоор стратегийн ордуудын хувьд Монголын болон гадаадын хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа ямар байх ёстой вэ”



Эх сурвалж: Нийгэм, эдийн засгийн барометер. Сантмарал судалгааны төв. 2016.

График 3. “Монголын талын эзэмшил ямар байх ёстой вэ”



Эх сурвалж: Нийгэм, эдийн засгийн барометер.
Сантмарал судалгааны төв. 2016.

Сантмарал судалгааны төвөөс явуулдаг нийгэм, эдийн засгийн барометрийн судалгаагаар нийт судалгаанд оролцсон 1500 иргэдийн 10 хувь нь 2012 онд уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх мөнгийг тарааж, иргэн бүр хүртэх ёстой гэж үзэж байсан бол 2016 онд 8.3 хувь болж буурсан. Засгийн газар тус мөнгийг нийгмийн халамжийн бодлогыг эрчимжүүлж бага орлоготой иргэдэд шууд өгөх ёстой гэж үзсэн иргэд 10-12.5 хувь болж өссөн. Харин Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт байх ёстой гэж үзсэн иргэд 30-40.3 хувь болж өссөн. Боловсрол, эрүүл мэнд г.м салбаруудад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж урт хугацааны нийгмийг хөгжүүлэх төслүүд байх ёстой гэж үзсэн иргэдийн хувь 35.9-45 хувь болж өссөн байна. Үүнээс харахад иргэд, олон нийтийн уул уурхайн талаарх сөрөг төсөөлөл илтэд буурч гадаадын хөрөнгө оруулалтад таатай хандах болсон төдийгүй нийгмийн халамжийн бодлогыг бууруулж ажлын байр бий болгох салбарууд тэр дундаа ирээдүй хойч үедээ чиглэсэн салбаруудад уул уурхайгаас төсөвт төвлөрсөн мөнгийг зарцуулах эрмэлзэлтэй байгааг харуулж байна.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Хүснэгт 1. Компанийн нийгмийн хариуцлагын ач холбогдлын үнэлгээ²¹

Ач холбогдол	Менежер	Ажилтан	Дундаж дүн
Маш их чухал	33.3	29.9	30.8
Нэлээд чухал	33.3	24.7	27.1
Чухал	20	28.6	26.2
Дундаж	10	15.6	14
Чухал биш	3.3	1.3	1.9
Тийм ч чухал биш	0	0	0
Огт чухал биш	0	0	0
Дүн	100	100	100


Эх сурвалж: “Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын асуудалд”
КНХ-ын хоёрдогч эх үүсвэрийн судалгаа. 2014.

Дээрх судалгааг уул уурхайн олборлох чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 2013 онд хамгийн их татвар төлсөн 10 компанийн 30 удирдлага, менежер, ажилчид нийлсэн нийт 144 судалгаанд оролцогчдын 96 хувь нь өөрсдийн компанийг нийгмийн хариуцлагатай ажилладаг гэж дүгнэсэн бол тухайн бүс нутагт ажиллаж амьдардаг 112 иргэн, 64 ЖДҮ эрхлэгч, нийт 176 судалгаанд оролцогчдын 32.4% хувь нь тухайн уул уурхайн компанийн үйл ажиллагаа орон нутгийн иргэдийн өрхийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлэхэд тодорхой нөлөө үзүүлээгүй гэж хариулсан байгаа нь компани болон иргэдийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголтын зөрүү маш өндөр байгааг харуулж буй юм.²²

²¹ Я.Отгонсүрэн, Б.Даваасүрэн, С.Бурмаа, Б.Угтахжаргал, Ч.Батбаатар нар. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын асуудалд. 2014.

²² Я.Отгонсүрэн, Б.Даваасүрэн, С.Бурмаа, Б.Угтахжаргал, Ч.Батбаатар нар. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын асуудалд. 2014.

График 4. Компанийн удирдлага, ажилчдын нийгмийн хариуцлагатай ажилд өгсөн ач холбогдлын үнэлгээ



Эх сурвалж: “Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын асуудалд”
КНХ-ын хоёрдогч эх үүсвэрийн судалгаа. 2014.

График 5. Иргэд, ЖДҮ эрхлэгчдийн нийгмийн хариуцлагатай ажилд өгсөн ач холбогдлын үнэлгээ



Эх сурвалж: “Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын асуудалд”
КНХ-ын хоёрдогч эх үүсвэрийн судалгаа. 2014.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

График 4-т компанийн удирдах түвшин болон дунд шатны менежерүүдийн дунд КНХ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай чухлын дарааллыг тогтооход нэгдүгээрт - тухайн орон нутгийн эрх ашиг нь хөндөгдсөн иргэдэд хандив өгөх, хоёрдугаарт – байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, гуравдугаарт – нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох, дөрөвдүгээрт – ажлын байраар хангах үйл ажиллагаанууд орсон байна. График 5-т иргэд, ЖДҮ эрхлэгчдийн дунд КНХ-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагааны хүлээлтийн нэгдүгээрт – нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах, хоёрдугаарт - өрхийн орлого, ажлын байр нэмэгдүүлэх, тэр нь тухайн орон нутгийн иргэд хамрагдах гэсэн байгаа нь хоёр тал хүлээлт ижил боловч түүнийг хэрэгжүүлэх чухлын дараалал өөр байгааг харуулна. Чухлын дараалал өөр байх нь хязгаарлагдмал нөөцөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас гарах үр дүн өөр байх шаардлагатай болж байна.

Дээрх судалгааны нөлөөллүүд нь шууд нөлөөллүүд бөгөөд үүнээс гадна шууд бус нөлөөллүүдийг авч үзэх шаардлагатай. Шууд бус нөлөөллүүд нь зөрчлийг бий болгох суурь нөхцөл болдог.

Ховд аймгийн Цэцэг сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сумдад нийт 118 оролцогчтой судалгаагаар уул уурхайн үйл ажиллагаа тухай орон нутгийн иргэдийн нийгмийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг харуулсан байна.


График 6. Нутгийн иргэд уул уурхайн ашиг шимийг жигд хүртдэг эсэх



Эх сурвалж: Б.Эрдэнэболор. Тогтвортой Хөгжлийн Төлөөх Хариуцлагатай Уул Уурхайн Санаачилга ТББ-ын зөвлөх. Төслийн болон уул уурхайн нийгмийн

нөлөөллийн судалгааны танилцуулга. Дэлхийн банкны “Уул уурхайн нийгмийн нөлөөлөл ба орон нутгийн хөгжил” төсөл. 2012.

График 7. Уул уурхайн үйл ажиллагааны ашиг шимийг хэн хүртдэг вэ?



Эх сурвалж: Б.Эрдэнэболор. Тогтвортой Хөгжлийн Төлөөх Хариуцлагатай Уул Уурхайн Санаачилга ТББ-ын зөвлөх. Төслийн болон уул уурхайн нийгмийн нөлөөллийн судалгааны танилцуулга. Дэлхийн банкны “Уул уурхайн нийгмийн нөлөөлөл ба орон нутгийн хөгжил” төсөл. 2012.

График 8. Сумын удирдлагууд уурхайн компанитай харилцахдаа нутгийн иргэдийн эрх ашгийн төлөө үр дүнтэй хамтран ажилладаг эсэх




Эх сурвалж: Б.Эрдэнэболор. Тогтвортой Хөгжлийн Төлөөх Хариуцлагатай Уул Уурхайн Санаачилга ТББ-ын зөвлөх. Төслийн болон уул уурхайн нийгмийн

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

нөлөөллийн судалгааны танилцуулга. Дэлхийн банкны “Уул уурхайн нийгмийн нөлөөлөл ба орон нутгийн хөгжил” төсөл. 2012.


График 9. Иргэний нийгмийн байгууллагууд уурхайтай харилцахдаа нутгийн иргэдийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадах эсэх



Эх сурвалж: Б.Эрдэнэболор. Тогтвортой Хөгжлийн Төлөөх Хариуцлагатай Уул Уурхайн Санаачилга ТББ-ын зөвлөх. Төслийн болон уул уурхайн нийгмийн нөлөөллийн судалгааны танилцуулга. Дэлхийн банкны “Уул уурхайн нийгмийн нөлөөлөл ба орон нутгийн хөгжил” төсөл. 2012.


Дээрх социологийн судалгаанаас харахад уул уурхайн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн иргэдийн дунд үл итгэлцэл, хардалт сэрдэлт зэрэг зөрчил үүсгэх хөрс нь болдог байх магадлалтай бөгөөд орон нутгийн захиргаа буюу төрийн байгууллагын төлөөлөл авлигад өртөх магадлалтай, иргэний нийгмийн байгууллагууд иргэдийн эрх ашгийг төлөөлөхүйц зохион байгуулалтын оновчтой бүтэц биш байгааг харж болно. Уул уурхайн компани болон иргэдийн хоорондын уул уурхайн үйл ажиллагаанаас өөр өөр зөрүүтэй хүлээлттэй байгаа нь зөрчлийг бий болгодог үндсэн шалтгаан болж байгааг харуулж байна.

График 10. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан төсвийн хэмжээ ба салбар (2010-2012)



Эх сурвалж: ОУИТБС-ын тайлан. <http://eitimongolia.mn/mn/donations/2010-2012>

Зураг 3. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан төсвийн хэлбэрүүд (2010-2012)



Эх сурвалж: ОУИТБС-ын тайлан. <http://eitimongolia.mn/mn/donations/2010-2012>

График 10 болон Зураг 3-ийг харахад боловсрол, эрүүл мэндийн салбарт тухайн жилийн нийгмийн хариуцлагын төсвийг зарцуулдаг боловч нийгмийн болон бусад салбарт зарцуулсан төсөв түүний 80 орчим хувьтай дүйцэхүйц хэмжээтэй байгаа бөгөөд зарцуулалтын хэлбэрийг харахад нийгмийн байгууламж, түүний тохижилт, олон нийтийн арга хэмжээ, сургалтын төлбөр зэрэгт их хэмжээний төсвийг зарцуулж байна. Гэтэл График 5-т харуулснаар


ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

иргэдийн ажлын байр, байгаль орчныг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанд төсвийн зарцуулалт хийгдээгүй байгааг харж болно.

2.3 Уул уурхайн үйл ажиллагааны зөрчлийн өртөг

Хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, ахуй амьдралд сөрөг нөлөө үзүүлж буй нь иргэд болон улсад эдийн засгийн их хэмжээний хохирлыг бий болгохоос гадна уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад их хэмжээний зардлыг бий болгодгийг Харвардын Кеннедийгийн Их Сургуулийн Нийгмийн Хариуцлагын Санаачилга болон Австралийн Күйнслэндийн Их Сургуулийн Уул Уурхайн Нийгмийн Хариуцлагын Институтын судлаачид хамтран судалсан байна. Судалгаанд дэлхийн хэмжээний уул уурхайн 50 төслүүдэд тохиолдсон зөрчлийн кэйс бүхий томоохон компаниуд оролцсон бодитой судалгаа болсон.²³ Гэвч зөрчил зөвхөн сөрөг үр дагавар руу хөтөлдөггүй, асуудлыг зохистой шийдвэрлэх арга замыг бий болгодог байх талтай гэдгийг анхаарах нь зүйтэй.

График 11. Компани ба орон нутгийн иргэдийн хооронд үүсдэг зөрчлийн шалтгаанууд



²³ Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. "Cost of Company-Community Conflict in the Extractive Sector." Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School. 13 дахь тал.

Эх сурвалж: Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. “Cost of Company-Community Conflict in the Extractive Sector.” Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School.

График 11-т хамгийн их зөрчил үүсгэдэг шалтгаан нь байгаль орчинтой холбоотой бохирдол, ус, газар, ой мод зэрэг нөөцийн өөрчлөлт, ажлын байр, татвар, орон нутгийн худалдан авалт зэрэг эдийн засгийн тэгш бус хуваарилалт, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, гэмт хэрэг, осол гэмтэл зэрэг аюулгүй байдал, орон нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй, харилцан ашигтай зөвшилцөхтэй холбоотой үйл ажиллагаануудаас хамгийн их зөрчил үүсдэг болохыг харуулсан. Энэхүү судалгааны хамгийн чухал дүгнэлт бол дээрхээс үүдсэн зөрчлүүд нь компанийн үйл ажиллагааны зардлыг хэрхэн нэмэгдүүлж борлуулалтын орлогод хэрхэн нөлөөлдгийг судалсанд байгаа юм.

Хүснэгт 2. Зөрчлийн өртгийг бий болгож буй хүчин зүйлс

Харуул хамгаалалт	Харуул хамгаалалтын компанийн зардал,
	Хамгаалалтын үйл ажиллагааны зардал, хашаа хайлс, эргүүлийн хамгаалалт, хяналтын систем,
	Хамгаалалтын байнгын сургалт, ажилчдын цаг зарцуулалт.
Төсөлд өөрчлөлт оруулах	Төслийг дахин загварчлах зардал, ERP систем шинэчлэлт, хуулийн багийн зардал.
Эрсдлийн менежмент	Төрөл бүрийн даатгал.
	Хуулийн болон зөрчлийг зохицуулах мэргэжлийн баг, сургалт.
Эд материалын хохирол	Хувийн өмч, дэд бүтцийн эвдрэл, гэмтэл.
Бүтээмжийн алдагдал	Үйл ажиллагаа дундаа тасалдах.
	Үйл ажиллагааг түр зогсоох.
	Шинэ төсөл хэрэгжүүлэх боломжоо алдах.
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тасалдалт, тодорхойгүй буцаалт, ажил таслалт.
	Бүтээгдэхүүн нийлүүлэлт, хангамж хойшлогдох.
	Хяналт шалгалтын дарамт.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

Хөрөнгө	Эд хөрөнгийн үнэ цэнийн алдагдал, борлуулалтын алдагдал, хулгай.
	Зээлийг хугацаанд нь төлөөгүй улмаас үүсэх алдагдал, төлөх чадваргүй болох.
	Шинээр хөрөнгө босгох хүндрэл.
	Үнийн тогтворгүй байдлаас өнөөгийн үнэ цэнээ алдах.
Хувь хүний	Ажилчдын эрсдэл болон зөрчлийг шийдвэрлэхэд зарцуулагдах хугацаа.
	Уулзалт, хэлэлцүүлэг зэрэг зөрчлийг шийдвэрлэхэд зарцуулах зардал.
	Хүн барьцаалах, ажилчдыг гэмтээх, нөхөн олговор олгох, ажилчдыг баривчлах.
	Стресс ба ёс зүйн доголдлоос үүдсэн нөлөөлөл.
	Өндөр цалин амлаж, бонус өгч зөрчлийг намдаах.
	Шинэ ажилтан авах, ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх сургалт
Нэр хүнд	Зөвлөх хөлслөх, мэдээлэл тараах зэрэгт олон нийтийн харилцаанд их зардал гаргах.
Залруулга	Хөрөнгө оруулагчийн таагүй байдал, бүтээгдэхүүний нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх, өрсөлдөх чадвар буурах.
	Нөхөн төлбөр.
	Эрүүл мэнд, боловсрол, сургалт, үйлчилгээний бусад хангамж, нөхөн сэргээлтийг хийхэд илүү өндөр үүрэг амлалт хүлээх.
	Захиргааны зохион байгуулалт, шийдвэр гаргалтын эмх замбараагүй байдлаас үүдсэн бусад зардал.

Эх сурвалж: Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. "Cost of Company-Community Conflict in the Extractive Sector." Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School.


Хүснэгт 2-т зөрчлийн өртгийн зардлууд нь зөрчлөөс хамгаалах зардлууд мөн зөрчлөөс үүдсэн зардал буюу ашиг, ирээдүйд үнэ цэнийг бий болгож чадаагүй

алдагдал гэж хоёр хувааж болохоор байна. Капитал зардал нь 3-5 тэрбум ам.долларын хооронд хэлбэлздэг дэлхийн хэмжээний уул уурхайн төслүүдийн үйл ажиллагаа доголдоход Өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV) нь 7 хоног тутамд 20 сая ам доллараар буурч байдаг гэж судалгааны багийнхан дүгнэсэн байна.

Шигтгээ 1.


Латин америкийн нэгэн компани 2010 онд уурхайн байгуулалтын үе шатанд төслийн ажил 9 сар хойшлогдсоноос бараа материалын үнийн өсөлт, өнөөгийн үнэ цэнийн алдагдлаас шалтгаалж 750 сая ам.долларын нэмэлт зардал гаргасан байна.

График 12. Уул уурхайн үе шат ба зөрчлийн тоо хэмжээ



Эх сурвалж: Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. “Cost of Company-Community Conflict in the Extractive Sector.” Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School.

График 13. Зөрчлүүдийн илрэл (Зөрчлүүд хэрхэн илэрдэг вэ)



Эх сурвалж: Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. "Cost of Company-Community Conflict in the Extractive Sector." Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School.

Зураг 11-т жагсаал, цуглаан хийх, ил тод байдлыг хангах, олон нийтэд түгээх, хяналт, зөвшөөрөл, захиргааны үйл явцуудад зөрчлүүд хамгийн ихээр илэрдэг болохыг харуулжээ. Энэ бүх үйл явцад цаг хугацааг алддаг нь ирээдүйн боломжуудыг алддаг гэсэн дүгнэлт гарч байгаа бөгөөд хамгийн их зөрчил уул уурхайн олборлолтын үед гарах магадлал ихтэйг харуулсан байна.

Шигтгээ 2.

Уул уурхайн томоохон компаниудын Гүйцэтгэх захирлууд хэлэхдээ: Тухайн орны уул уурхайн төсөл нь манай компанийн нийт эргэлтийн 5 хувь нь бөгөөд бид хөрш орнууд болон дэлхий даяар бизнесийн олон салбартай бид зөвхөн энэ төсөлд зарцуулах цаг хугацаа байхгүй. Энэ зөвхөн мөнгөний тухай биш харин ирээдүйн боломжийн өртгийг (opportunity cost)-ийг алдаж буй тухай юм.

Рэйчил Дэвис болон Даниэл Фрэнкс нарын хийсэн энэхүү судалгаа нь уул уурхайн зөрчил нь зөвхөн орон нутгийн иргэдэд нөлөөлөөд зогсохгүй компанийн зардлыг өсгөдөг болохыг харуулсан чухал судалгаа болсон. Үүгээрээ тэд КНХ-ыг сайн дурын үйл ажиллагаа бус компанийн өөрийн эрсдэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлдэг стратегийн төлөвлөлт болохыг баталсан юм.

III БҮЛЭГ. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ БА САНААЧИЛГА

3.1 Уул уурхайн хариуцлагыг сайжруулах санаачилгын ач холбогдол

Уул уурхайн хариуцлагыг сайжруулах санаачилга (Initiatives) гэдэгт уул уурхайн салбарыг хариуцлагатай, тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн аливаа байгууллага өөрийн сайн дурын үндсэн дээр хэрэглэдэг баримт бичгүүд (*стандарт, удирдамж, зөвлөмж, хөтөлбөр, зарчим, сертификат, гарын авлага, аргачлал, тайлан*)-ийг хамруулан ойлгоно.

Зураг 1. Санаачлагуудын хэлбэр



Уул уурхайг тогтвортой хөгжүүлэх хүрээнд олон санаачилгууд гарсан бөгөөд тэдгээрээс уул уурхайн салбарт танигдсан, улс орнууд түгээмэл ашигладаг санаачилгуудыг сонгосон. Олон улсын банк, хандивлагчдаас зээл хүсэж буй компаниуд нь үндэсний зохицуулалтаас гадна олон улсын түвшинд дагаж мөрддөг стандартуудыг мөн адил мөрдөх ёстой болдог. Эдгээр стандарт, бодлогууд нь олон улсын санхүүгийн институц бүрд ялгаатай байдаг ч нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, орон нутгийн иргэд болон тэдний амьдарч буй байгаль орчныг хамгаалан хөгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхой тусгасан байдаг. Судалгаанд хамруулсан санаачилгууд нь нийтлэг зорилго, ач холбогдолтой бөгөөд улс орнууд, холбоо, байгууллагууд өөр өөрийн онцлогт тохируулан шууд болон хэсэгчлэн хэрэглэдэг.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Тэдгээрийн нийтлэг зорилго, ач холбогдол нь:

- Өрсөлдөх давуу талыг нэмэгдүүлж, зардал бууруулж, урт хугацааны тогтвортой орлогыг бий болгоно.
- Оролцогч талуудын дэмжлэг ялангуяа засгийн газар, иргэдтэй харилцах үйл явц сайжирна.
- Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийг татах үнэлэмж нэмэгдэнэ.
- Ажилтнуудын зүгээс бүтээмж нэмэгдэж, ёс зүйн дэмжлэг бий болно. Сэтгэл ханамж эрс нэмэгдэнэ.

3.2 Хариуцлагатай уул уурхайн Монгол Улсын туршлага

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх Монгол Улсын санаачилга өмнөх хэсэгт дурьдсанчилан 2007 оноос эхлэлтэй бөгөөд 2017 оныг хүртэл дараах санаачилгуудыг дотоодын буюу Монгол Улсын санаачилга гэж авч үзсэн.

Зураг 2. ХУУ-н Монгол Улсын туршлага (оны дарааллаар)



1. **Хариуцлагатай уул уурхайн Санаачилгын Тунхаг бичиг:** Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга 2006 оноос эхлэлтэй бөгөөд Азийн сангийн дэмжлэгтэйгээр төр, төрийн бус, хувийн болон бизнесийн байгууллагууд, судлаачид бүхий оролцогч талууд 2007 онд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх Хариуцлагатай уул уурхайн Санаачилгын Тунхаг бичгийг боловсруулан гаргаж, түүнд 80 гаруй байгууллага, иргэдийн төлөөлөл нэгдэн орж гарын үсгээ

зурсан.²⁴ Олон талт уулзалтын нэгдсэн хуралдаанаар ХУУ-н тодорхойлолт, зарчмыг дараах байдлаар тодорхойлсон: Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт - Бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль сахиx ёсыг дээдэлсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг “Хариуцлагатай уул уурхай” гэж ойлгоно гээд эрдэс баялгийг хайх, олборлох үйл ажиллагааг хариуцлагатайгаар гүйцэтгэхэд дараах 8 зарчмыг²⁵ хэрэгжүүлэх шаардлагатай болохыг тохиролцсон байна. Үүнд:²⁶

1. Олон талын оролцоог хангах,
2. Ил тод, нээлттэй байх,
3. Хуулийг сахин дээдлэх,
4. Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх,
5. Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах,
6. Үр өгөөжтэй байх,
7. Хүмүүнлэг ёс зүйтэй байх,
8. Дэвшилтэт технологид суурилсан байх.

1. **“Хариуцлагатай уул уурхайн гарын авлага”- Responsible Mining Guideline, 2017 он.** НҮБХХ, ИБУИНВУ-ын ЭСЯ-ны дэмжлэгтэй Хариуцлагатай уул уурхайн санаачлага ТББ-ын боловсруулсан гарын авлага. Тус гарын авлага нь өмнөх бүлэгт дурдсан 8 зарчмыг хэрэгжүүлэхэд шаардагдах шаардлагуудаас гадна уул уурхайн амьдралын мөчлөгт бий болдог үйл явцыг энгийн ойлгомжтой хэлбэрээр нарийвчилан тайлбарласан. Дэлгэрэнгүйг доорхи холбоосоос харна уу.
<http://responsiblemining.mn/wp-content/uploads/2017/10/Gariin-avлага-UNDP.pdf>

²⁴ Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. “Cost of Company-Community Conflict in the Extractive Sector.” Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School. 13 дахь тал.

²⁵ Зарчим гэдгийг хамрах хүрээ гэж ойлгож болно.

²⁶ A framework for cooperative decision – making. Flyer of Asia foundation. 2007.

2. "Хариуцлагатай уул уурхай" сургалтын гарын авлага - "Responsible mining" Training manual, 2016: НҮБХХ, Австралийн Квинсландын Их Сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн хүрээлэн, Иргэний шийдэл Бодлогын судалгааны хүрээлэнгээс гаргасан. Энэ гарын авлага хариуцлагатай уул уурхайн бүхий л асуудлыг хамруулан авч үзэхийг зориогүй бөгөөд энэ төслийн хүрээнд хийсэн өргөн хүрээтэй тойм судалгаа, орон нутагт хийсэн хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд тогтоосон гол сэдэв, асуудлуудыг онцлон авч үзсэн. Хамрах хүрээ:

- Хариуцлагатай уул уурхай ба тогтвортой хөгжил,
- Олон нийтийн оролцоо,
- Нийгмийн нөлөөллийн менежмент,
- Уул уурхай ба орон нутгийн хөгжил,
- Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл ба байгаль орчны засаглал,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ,
- Усны менежмент,
- Уул уурхайн нөхөн сэргээлт,

3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга – Extractive Industries Transparency Initiatives: ОУИТБС нь анх 2002 онд Иохансбург хотноо болсон Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхий сайд Тони Блэйр олборлох салбарт ил тод байдлыг хангах норм, стандарттай болох санаачилгыг гаргаж анхны хувилбарыг танилцуулснаас хойш 2013, 2016 онуудад стандартаа шинэчлэн сайжруулсан. Өдгөө 48 улсыг эгнээндээ багтаасан бөгөөд Монгол Улсын хувьд 2006 оноос гишүүн болж стандартын дагуу тайлангаа гаргаж байна. Хамрах хүрээ:

- Компаниудын ерөнхий мэдээлэл,
- Уул уурхайн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл,
- Нөхөн сэргээлтийн мэдээ, тээврийн зардал,
- Бүтээгдэхүүн борлуулалтын мэдээ,
- Дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт, бартерийн гэрээ, нийгмийн зарцуулалт, зээл болон зээлийн баталгааны мэдээлэл,
- Бенефициар өмчлөгчийн талаарх мэдээлэл,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэл,

- Ногдол ашгийн мэдээлэл,
- Нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлал болон хөндлөнгийн аудитын мэдээлэл,
- Ажилчдын мэдээлэл,
- Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээний мэдээлэл,
- Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалыг компаниудын төлсөн мөнгөн бус орлогын талаарх мэдээлэл,
- Төрийн байгууллагуудтай ТӨААН-ийн хийсэн шилжүүлэг,
- Төсвийн хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл,

4. Монгол Улсын тогтвортой санхүүжил (ТОС)-ийн зарчим Уул уурхайн салбарын удирдамж. Монголын банкуудын холбоо. 2015.

Уул уурхайн салбарын энэхүү удирдамж нь уул уурхайн салбарын харилцагчдад зээл олгохтой холбоотойгоор үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн (БОНХ) эрсдэл, боломжийг үнэлэхэд нь банкуудад дэмжлэг үзүүлэх зорилготой. Удирдамжийг дараах үйл ажиллагааг дэмжих зорилготойгоор энэхүү зарчим, тунхаг бичиг, хөтөлбөрийг 2013 онд гаргасан. Хамрах хүрээ:

- Байгаль орчныг хамгаалах,
- Ажилчид болон орон нутгийн иргэдийг хамгаалах,
- Түүх, соёлын өвийг хамгаалах,
- Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих,
- Санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох,
- Ес зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих,
- Хариуцлагатай, ил тод байдлыг дэмжих,
- Манлайлан үлгэрлэх,

5. Үйл ажиллагааны сайн дурын кодекс: Уул уурхайн салбар ба усны менежмент – Voluntary Code for Practice: Minerals Industry and Water Management: ҮАСДК нь ОУВС-ын дэмжлэгтэйгээр говийн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын усны үр ашигтай, ил тод хэрэглээг дэмжиж орон нутаг дахь оролцогч талуудтай харилцах харилцаанд итгэлцэл бий болгох чухал алхам болох юм. Хамрах хүрээ:

- Хариуцлагатайгаар ил тод байх,

- Үндэсний хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцэж ажиллах,
- Санаачилгатай харилцаж оролцоог хангах,
- Усны нөөцийн үр дүнтэй менежмент ба хамгаалал,
- Эерэг нөлөөллийн бий болгох,
- Орон нутгийн улсын дэд бүтэц ба холбогдох үйлчилгээг дэмжих.

3.3 Хариуцлагатай уул уурхайн олон улсын туршлага

Уул уурхайг хариуцлагатай эрхлэхэд дэмжих зорилготой хэд хэдэн баримт бичгүүд, санаачилгууд гарсан байдаг. Тэдгээрийн хамрах хүрээ, агуулгуудыг харьцуулж дотоодын санаачилгыг сайжруулах боломжтой.

Уул уурхайн тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайтай холбоотой судалгаануудад хамгийн их иш татагдсан болон ОУ-д нэр хүндтэй түгээмэл 23 санаачилгууд бүхий жагсаалт гаргаж тэдгээрийг чухал, дунд, бага дунд хамааралтай гэж ангилан шаардлагуудыг харьцуулсан. Үүнд:

Чухал хамааралтай:

6. Хариуцлагатай уул уурхайн стандарт - IRMA Standart for Responsible

Mining IRMA-SDT-001 Draft v2.0, 2016: Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын санаачилга олон улсын байгууллага IRMA нь 2014 онд Хариуцлагатай уул уурхайн стандартыг /Irma standard for responsible mining IRMA STD-001 Draft v2.0/ санаачлан боловсруулж үйлдвэрчний эвлэл, уул уурхайн компани, мэргэжлийн судлаач, иргэний нийгмийн байгууллага, нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдээс санал авч сайжруулах үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэхүү стандарт нь уул уурхай эрхлэгчдийн хувьд хүний эрх, байгаль орчны тогтвортой байдалд суурилсан үйлдвэрлэл явуулж буйн баталгаа болох төдийгүй тэр чиглэлд хөтлөх удирдамж нь болгохыг зорилгоо болгожээ. Үндсэн 4 хүрээтэй. Энэ нь Нийгмийн хариуцлагын ISO 26000 стандартыг бүхэлд нь 1 хэсэг болгон авч үлдсэн 3 хэсэгт уул уурхайн салбарын чухал асуудлыг оруулж нөхөж өгснөөрөө онцлог, илүү ахисан түвшинд авчирсан. Хамрах хүрээ:

- Бизнесийн уялдаа холбоо
 - Хуулийн нийцэл
 - Ашиг орлого ба төлбөрийн ил тод байдал (Eiti)

- Нийгмийн хариуцлага,
 - Шударга хөдөлмөр ба ажлын шаардлагуудын нөхцөл
 - Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй байдал
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал ба аюулгүй ажиллагааны шаардлага
 - Онцгой байдлын үед авах шаардлагатай арга хэмжээ ба шаардлагатай хариу арга хэмжээ
 - Хүний эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд ба хянан нийцүүлэлт
 - Уурхай ба зөрчилд хүрч болохуйц өндөр эрсдэлтэй хэсгийн шалгуур үзүүлэлтүүд
 - Харуул, хамгаалалтын зохицуулалт
 - Орон нутгийн иргэд ба оролцогч талуудын оролцоо
 - Орон нутгийн иргэдийн дэмжлэгийг авах ба үр өгөөжийг хүргэх шаардлагууд
 - Соёлын өвийг хамгаалахтай холбоотой шаардлагууд
 - Нүүлгэн суурьшуулах
 - Гомдол гаргах механизм ба түүнийг засах боломжтой болгох шаардлагууд
 - Байгаль орчны хариуцлагатай холбоотой шалгуур үзүүлэлтүүд
 - Усны чанарын шаардлагууд
 - Усны хэмжээ, түвшний шаардлагууд
 - Уурхайн хог хаягдлыг зохицуулах шаардлагууд
 - Агаарын чанарын шаардлагууд
 - Дуу, чимээтэй холбоотой шаардлагууд
 - Хүлэмжийн хийг бууруулах шаардлагууд
 - Тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой шаардлагууд
 - Тусгай хамгаалалттай газар нутгаас гаднах биологийн олон төрөл зүйлийг хамгаалах шаардлагууд
 - Цианидтай холбоотой зохицуулалттай холбоотой шаардлагууд
 - Мөнгөн устай холбоотой зохицуулалттай холбоотой шаардлагууд
 - Эерэг өв уламжлал үлдээх төлөвлөлт ба удирдлага
 - Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үнэлгээний шаардлагууд
 - Нөхөн сэргээлт ба хаалттай холбоотой шаардлагууд

7. Хариуцлагатай уул уурхайн индекс – Responsible mining index draft methodology: ХУУИ-ийг Нидерланд улсын Амстердам хотод байрлах

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Хариуцлагатай уул уурхайн сан гаргах бөгөөд. Уг сан нь Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага болон ижил төстэй зорилготой сайн үйлсийн сангуудаас санхүүждэг. Уул уурхайн компаниудаас санхүүжилт авдаггүй байхаар ажиллах зарчмаа тодорхойлсон байна. Эрдэс баялаг, металлын салбарт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудыг эдийн засаг, байгаль орчин, нийгэм болон засаглалын үзүүлэлтүүдээр эрэмбэлж, эрдэс баялаг, металлын салбарын шилдэг, сайн туршлагыг илрүүлж олон нийтэд таниулах замаар энэ салбарыг илүү их хариуцлагатай хөгжүүлэх зорилготой. Хамрах хүрээ:

- Эдийн засгийн хөгжил,
- Бизнесийн ёс зүйн хэм хэмжээ,
- Уурхайн үйл ажиллагааны үе шатны удирдлага,
- Орон нутгийн иргэдийн сайн сайхан,
- Хөдөлмөрийн нөхцөл,
- Хүрээлэн буй орчны хариуцлага гэсэн 6 хүрээг хамрахаас гадна уурхайн түвшин дэхь үзүүлэлтүүдийг тусад нь гаргасан байна. Үүнд:
 - Нөлөөллийн үнэлгээг хийж нийтэд мэдээлэх,
 - Орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, тэр дундаа эмэгтэйчүүд, залуучуудад боломж олгодог эсэх
 - Санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох,
 - Устай холбоотой шийдвэр гаргалтад орон нутгийн иргэдийг оролцуулж хамтарсан усны чанарын мониторинг хийх,
 - Онцгой байдалд бэлэн байх.

8. ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт - IFC Performance Standards on Environmental and Social Sustainability, 2012: ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт нь ОУВС-ын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх арга замын нэг бөгөөд энэхүү баримт бичиг нь байгаль орчин болон нийгмийн тогтвортой байдалтай холбоотой ОУВС-ын амлалт, үүрэг хариуцлагыг илэрхийлдэг. Хамрах хүрээ:

- Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн менежментийн үнэлгээ,

- Хөдөлмөр болон ажлын байрны нөхцөл,
- Байгалийн нөөцийг үр дүнтэй ашиглах, агаарын бохирдлоос сэргийлэх,
- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон аюулгүй байдлыг сайжруулах,
- Газар эзэмшил болон сайн дурын бус дахин суурьшуулахыг эв зүйгээр шийдвэрлэх,
- Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх,
- Уугуул иргэдийн эрх ашгийг хүндэтгэх,
- Соёлын өвийг хамгаалах.

9. Тогтвортой уул уурхайн төлөө санаачилга - Towards sustainable mining initiative. Канадын Уул Уурхайн Холбоо, 2004. Канадын уул уурхайн холбооноос 2004 онд гишүүн байгууллагуудынхаа нийгмийн хариуцлагыг сайжруулах зорилготойгоор гаргасан сайн дурын үндсэн дээр хийгддэг тайлагнал дээр үндэслэсэн гүйцэтгэлийг үнэлэх систем юм. Мөн жил бүр хамгийн сайн үнэлгээтэй компаниудыг зарладаг. Хамрах хүрээ:

- Уугуул иргэд ба орон нутгийн иргэдийн оролцоог хангах,
- Хямралын эсрэг менежментийн төлөвлөгөө,
- Эрүүл аюулгүй байдал,
- Хүүхдийн болон хүчээр хөдөлмөр эрхлүүлэхээс сэргийлэх,
- Биологийн төрөл зүйлийг хамгаалах менежмент,
- Хаягдлын далангийн менежмент
- Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгаруулалтын менежмент,

Дунд хамааралтай:

10. Уул уурхай ба металлын ОУ-ын зөвлөлийн 10 зарчим - ICMM 10 principles: 1998 онд уул уурхайн салбарын 9 том компани хамтарч салбарын тулгамдаж буй асуудлыг хамтарч шийдэх зорилготойгоор ОУ-ын уул уурхайн санаачилга (Global Mining Initiative) хөтөлбөрийг санаачилсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд “Уул уурхайн ба металлын тогтвортой хөгжил” төслийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Энэ төслийн явцад компаниуд эрсдэлийг бууруулахаар амбицтай

амлалтуудыг өгсөн. Үүний дараагаар Уул уурхай ба металлын ОУ-ын зөвлөл²⁷ нь 2001 онд байгуулагдсан. Хамрах хүрээ:

- Ёс зүйтэй бизнесийн туршлага болон компанийн засаглалыг зохистой байдлаар хэрэгжүүлж хангах,
- Компанийн шийдвэр гаргах процессыг тогтвортой хөгжилтэй уялдуулах,
- Хүний үндсэн эрхийг хангах болон компанийн үйл ажиллагаанд өртсөн ажилчид болон бусад хүмүүстэй тохиролцох замаар соёл, уламжлал, үнэт зүйлийг нь хүндэтгэх,
- Баталгаатай тоон мэдээлэл болон зохистой шинжлэх ухаан үндэслэсэн эрсдэлийн менежментийн стратегийг хэрэгжүүлэх,
- Эрүүл мэнд болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг тогтмол сайжруулах арга замыг хайх,
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг багасгах, тогтмол сайжруулах арга замыг хайх,
- Биологийн төрөл зүйл болон газар төлөвлөлттэй холбогдох нөхцөл байдлыг хүндэтгэх, хамгаалах
- Хариуцлагатай хэрэглээ, бүтээгдэхүүнийг дахин ашиглахыг дэмжих,
- Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах,
- Оролцогч талуудтай үр дүнтэй, ил тод харилцаатай байх болон тайлагналыг хараат бус байдлаар гүйцэтгэх.

11. Уул уурхайн тогтвортой хөгжлийн замын зураг: Атлас - Mapping Mining to the Sustainable Development Goals: An Atlas, 2016: Дэлхийн эдийн засгийн форум, НҮБХХ, Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой хөрөнгө оруулалтын Колумбия төв. Даян дэлхийн хөгжлийн зорилт болох Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад уул уурхайн салбар онцлох үүрэг рольтой гэж үзэж 2016 онд Тогтвортой хөрөнгө оруулалтын Колумбын төв, Тогтвортой хөгжлийн шийдэл сүлжээ, НҮБХХ, Дэлхийн эдийн засгийн форум, ОУГХАН хамтран Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх уул уурхайн газрын зураг баримт бичгийг уул уурхайн компаниудын үйл ажиллагаагаа явуулахдаа тогтвортой хөгжлийн зорилтруу чиглэхэд шаардлагатай холбоосыг бий болгох зорилгоор санаачлан боловсруулсан. Энэхүү баримт бичиг нь тогтвортой хөгжлийн

²⁷ ОУ-ын International Mining and Metals Council (ICMM)

17 зорилтыг уул уурхайн салбарын бүхий л үйл ажиллагаанд хэрхэн тусгаж ойлгож, хэрэгжүүлэх боломжтой сайн туршлагыг зөвлөж, санал болгосон уул уурхайн салбарыг хариуцлагатайгаар хөгжүүлэх чухал удирдамж бүхий санаачилга. Бүтцийн хувьд бүх зорилтуудыг уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компани, засгийн газар, орон нутгийн захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний институциуд хэрхэн ойлгож ажил хэрэгтээ тусгаж, хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй тайлбартай. Хамрах хүрээ:

1. Байгаль орчны тогтвортой байдал: Уул уурхайн үйл ажиллагаа нь газар, ус, цаг агаар, ургамал, амьтны аймагт нөлөөлдөг бөгөөд хүмүүс эдгээр байгалийн нөөцөөс хамааралтай амьдардаг.

- Тогтвортой хөгжлийн зорилт 6 – Ус ба эрүүл ахуй, Тогтвортой хөгжлийн зорилт 15 – Амьд байгаль болон газар: Уул уурхайн үйл ажиллагаа нь газар буюу хөрс болон усыг зайлшгүй хэрэглэх бөгөөд энэхүү хэрэглээгээрээ экосистемийн ойн, цөлжилт, хөрсний доройтол, биологийн төрөл зүйлийг устгах, сулруулах зэргээр нөлөөлдөг тул үүнээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг багтаасан байна.
- Тогтвортой хөгжлийн зорилт 7 – Эрчим хүчний хүртээмж ба тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн зорилт 13 – Цаг агаарын өөрчлөлттэй тэмцэх: Уул уурхайн үйл ажиллагаа нь эрчим хүч болон хортой бохирдол ялгаруулалт ихтэй бөгөөд энэ утгаараа сайн туршлагыг нэвтрүүлэх аваас эрчим хүчний хэмнэлтийг хамгийн сайн хийх боломжтой салбар гэж тооцогддог.

2. Нийгмийн оролцоо: Уул уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдэд эдийн засгийн боломж олгохоос гадна амьдрах таатай орчин бүрдүүлэх хүний эрхийг хамгаалахад чухал нөлөө үзүүлнэ.

- Тогтвортой хөгжлийн зорилт 1 – Ядуурлыг бууруулах, Тогтвортой хөгжлийг зорилт 5 – Жендерийн тэгш байдал, Тогтвортой хөгжлийн зорилт 10 – Тэгш бус байдлыг бууруулах: Уул уурхай нь татвараараа төсөвт их хэмжээний санхүүжилтийг төвлөрүүлж үүгээр нь засгийн газрууд эдийн засгийн бусад салбар, нийгмийн хөгжилд хөрөнгө оруулалт хийхээс гадна уул уурхай нь ажлын байрыг ихээр бий болгож орон нутагт бизнесийн орчинг

бүрдүүлдэг. Уул уурхайн компаниуд нь орон нутгийн иргэдийн оролцоог хангах хандлагатай байхаас шалтгаалж уул уурхайн талаар бодитой ойлголтыг өгч үүгээрээ маш чухал нөлөөг үзүүлдэг. Уул уурхайн компаниуд нь уурхайн үйл ажиллагаа, ашиг, үр шимийн тэгш хуваарилалт, санал гомдлын мөрөөр гарах шийдвэрт бүлгүүд тэр дундаа эмэгтэйчүүдийн дуу хоолойг тусгах, оролцоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг хийснээр тэгш бус байдлыг арилгахад чухал хувь нэмэр оруулна.

- Тогтвортой хөгжлийн зорилт 16 - Тайван, бүгдийг хамарсан нийгмийг дэмжих, шударга ёсыг бүгдэд хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүгдийг хамарсан тогтолцоог бий болгох: Уул уурхайн компаниуд нь орон нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэж, хуулийг дээдэлснээр компани, орон нутгийн иргэдийн хооронд дахь зөрчлөөс сэргийлж тайван нийгмийг бий болгох боломжтой бөгөөд санхүүжилтийн үйл явцыг ил тод тайлагнаснаар хууль бус санхүүжилт, авлига зэргээс сэргийлж чадна.

3. Эдийн засгийн хөгжил: Уул уурхай нь эдийн засгийн хөгжлийн хувьд орон нутаг, бүсийн болон үндэсний хэмжээнд дэд бүтцийг хөгжүүлэх, шинэ техник технологийг нутагшуулах болон ажиллах хүчний өсөлтөд чухал нөлөө үзүүлдэг.

- Тогтвортой хөгжлийн зорилт 8 – Сайн хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн өсөлт: Уул уурхай нь орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих, сургалт хийх, уул уурхайн үйл ажиллагаанд хэрэглэгдэх төрөл бүрийн үйлчилгээг хангах бизнесийн боломжуудыг бий болгох шинэ боломжуудыг нээж өгдөг.
- Тогтвортой хөгжлийн зорилт 9: Найдвартай дэд бүтэц, инноваци, үйлдвэржилт, Тогтвортой хөгжлийн зорилт 12 – Хариуцлагатай хэрэглээ: Уул уурхай нь шууд болон шууд бусаар дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулж эдийн засгийн өсөлтийг төрөлжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Мөн ханган нийлүүлэлтийн бодлогоороо зохистой хэрэглээг дэмжиж хог хаягдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.

12. Эквадорын зарчим - The Equator Principles: Эквадорын зарчим нь төслийн байгаль орчин болон нийгмийн эрсдэлийг тодорхойлж үнэлэх, удирдахад зориулагдсан санхүүгийн институциудын гаргасан эрсдэлийн менежментийн хүрээ юм. Эквадорын зарчмыг 89 санхүүгийн байгууллага, 37 улс орон албан ёсоор өөрийн үнэлгээний аргачлал болгон хэрэглэдэг. 10 зарчимтай. Хамрах хүрээ:

- Төрөлжүүлэх,
- Байгаль орчин ба нийгмийн үнэлгээ,
- Тухайн улс оронд тохирох, шаардлагатай байгаль орчин ба нийгмийн стандартуудад тааруулах,
- Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем ба Эквадорын зарчмын дагуух үйл ажиллагааны төлөвлөгөө,
- Оролцогч талуудын оролцоо,
- Санал, гомдол гаргах механизм,
- Хараат бус тайлан,
- Гэрээ, хэлэлцээр, тохиролцоо,
- Хараат бус хяналт шинжилгээ ба тайлагнал,
- Тайлагнал ба ил тод байдал.

13. Нийгэм, эдийн засгийн аргачлал - Social Economic Assessment Toolbox, 2012. Энэхүү аргачлал нь уурхайн үйл ажиллагааг нэвтрүүлэхдээ тулгарч буй нийгэм, эдийн засгийн бэрхшээл, нөлөөллүүд, хүний эрхэд нөлөөлж буй нөлөө зэргийг холбогдох баримт мэдээнд тулгуурлан хийх зорилготой олон жилийн турш туршигдан сайжирсан ОУ-д түгээмэл хэрэглэгддэг аргачлал юм. Хамрах хүрээ:

- Уурхайн үйл ажиллагааны танилцуулга,
- Орон нутгийн байдлыг нарийвчлан тодорхойлох, оролцогч талуудын оролцоог хангах,
- Нөлөөллийг тогтоох, асуудлыг үнэлэх,
- Нийгмийн гүйцэтгэлийн менежмент,
- Нийгэм, эдийн засгийн үр шимийг түгээх,
- Нийгмийн менежментийг төлөвлөгөөг боловсруулах,
- Нийгэм, эдийн засгийн үнэлгээг тайлагнах,

14. Зүүн өмнөд азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг ASEAN -ын олборлох үйлдвэрлэлийн засаглалын хүрээ. - ASEAN

Framework for extractive industries governance in ASEAN: ASEAN-ны Олборлох үйлдвэрлэлийн засаглалын хүрээ нь гишүүн орнуудын уул уурхайн салбарын интеграцчлалыг дэмжих зорилгоор 2014 онд гаргасан тогтвортой хөгжлийн баримт бичиг юм. Хамрах хүрээ:

- Байгаль орчныг хамгаалах,
- Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах,
- Ил тод, хариуцлагатай үйл ажиллагаа,
- Зохистой санхүүгийн төлөвлөлт ба ашиг орлогын менежмент.

15. CCCMC-ын гадаадын уул уурхайн салбарт хөрөнгө оруулахад баримтлах нийгмийн хариуцлагын гарын авлага – CCCMC (China Chamber of Commerce of Metals and Chemicals Importers and Exporters) Guidelines for Social Responsibility in Outbound Mining Investment: Хятадын эрдэс баялаг, химийн бүтээгдэхүүн импортлогч болон экспортлогчдын худалдааны тэнхим нь гишүүн байгууллагуудынхаа гадаадад хөрөнгө оруулах, бүтээгдэхүүнээ экспортлоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой нийгмийн хариуцлагын гарын авлагыг 2014 гаргасан байна. Хамрах хүрээ:

- Байгууллагын засаглал,
- Шударга үйл ажиллагаа,
- Үнэ цэнийн гинжин хэлхээг бий болгох менежмент,
- Хүний эрх,
- Хөдөлмөр эрхлэлт,

Баримтлах зарчим:

- Шаардлагатай бүхий л хууль тогтоомжийг мөрдөх,
- Ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах,
- Хүний эрхийг хүндэтгэж ажилчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах,
- Байгал орчинг хамгаалж хүндэтгэх,
- Оролцогч талуудыг хүндэтгэх,
- Олборлох салбарын үнэ цэнийн гинжин хэлхээг бий болгох замаар хариуцлагыг бэхжүүлэх,
- Ил тод байдлыг хангах.

16. Хариуцлагатай эрдэс баялгийн хөгжлийн санаачилга - Responsible Mineral Development Initiative, 2011: Дэлхийн Эдийн Засгийн Форумаас

2011 онд Хариуцлагатай уул уурхайн хөгжлийг нэмэгдүүлэх хүрээг гаргасан. Хамрах хүрээ:

- Оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, туршлага солилцох ажлыг үр дүнтэй зохион байгуулах,
- Ашиг орлого, зарлага, эрсдэл болон хариуцлагын талаар нэгдсэн ойлголттой болох,
- Уул уурхайн амьдралын мөчлөгийн үе шатуудад оролцогч талуудын оролцоог хангах,
- Уурхайн үйл ажиллагааг ил тод байлгах,
- Санал, гомдол хүлээж авах, хяналт шинжилгээ хийх, албадлагын бус арга барилтай байх,
- Асуудлыг эртнээс цогцоор шийдвэрлэх менежменттэй байх.

17. Тайлагналын ОУ-ын санаачилга – GRI Global reporting initiative 2014:

Тайлагналын ОУ-ын санаачилга нь анх 1999 онд тогтвортой хөгжлийн тайлангийн гарын авлага хэлбэртэйгээр гарч байсан өдгөө Нидерланд улсын Амстердам хотод ОУ-ын хараат бус стандартчиллын байгууллага болон өргөжиж 2015 оны байдлаар 7500 гаруй байгууллага энэхүү тайлагналын системийг хэрэглэсэн байна. Хамрах хүрээ:

- Ил тод байдлын суурь тайлан,
- Менежментийн арга барилын тайлан,
- Эдийн засгийн гүйцэтгэлийн тайлан,
- Зах зээлийн нийцлийн тайлан,
- Шууд бус эдийн засгийн нөлөөний тайлан,
- Худалдан авах ажиллагааны тайлан,
- Авлигын эсрэг тайлан,
- Өрсөлдөөний эсрэг зан үйлийн тайлан,
- Бараа материалын хэрэглээний тайлан,
- Эрчим хүчний тайлан,
- Усны тайлан,
- Биологийн төрөл зүйлийн тайлан,
- Хорт хий ялгаруулалтын тайлан,
- Шингэн болон хатуу хог хаягдлын тайлан,
- Байгаль орчны нийцлийн тайлан,

- Ханган нийлүүлэгчдийн байгал орчны үнэлгээний тайлан,
- Ажил эрхлэлтийн тайлан,
- Хөдөлмөрийн менежментийн харилцаа,
- Ажил мэргэжлээс шалтгаалсан эрүүл мэнд, аюулгүй байдлын тайлан
- Сургалт болон боловсролын тайлан,
- Төрөлжүүлэлт болон тэгш боломжийн тайлан,
- Ялгаварлан гадуурхалтын эсрэг тайлан,
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тайлан,
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тайлан,
- Албадан хөдөлмөр эрхлэлтийн тайлан,
- Аюулгүй байдал, хамгаалалтын тайлан,
- Уугуул иргэдийн эрхийн тухай тайлан,
- Хүний эрхийн үнэлгээний тухай тайлан,
- Орон нутгийн иргэдийн тайлан,
- Ханган нийлүүлэгчдийн нийгмийн үнэлгээний тайлан,
- Бодлогын баримт бичгийн тайлан,
- Хэрэглэгчийн эрүүл мэнд болон аюулгүй байдлын тайлан,
- Маркетингийн тайлан,
- Үйлчлүүлэгчийн нууцлалын тайлан,
- Нийгэм, эдийн засгийн нийцлийн тайлан.

Бага, дунд хамааралтай:

18.ISO 26000 - Нийгмийн хариуцлагын стандарт - Corporate social responsibility standard, 2010: Нийгмийн хариуцлагын энэхүү сайн дурын удирдамж нь 2010 онд тогтвортой хөгжилд хувь нэмрээ бүх талууд жигд оруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Энэхүү удирдамж нь бүх салбарыг хамруулсан байдаг тул уул уурхай үйл ажиллагааны хамгийн эмзэг хэсэг болох олон нийтийн оролцоо, байгаль орчин тэр дундаа усны асуудлыг дэлгэрэнгүй тусгаагүй байна. Хамрах хүрээ:

- Байгууллагын засаглал,
- Хүний эрх, эрх чөлөө,
- Хөдөлмөрлөх эрх,
- Хүрээлэн буй орчин,

- Шударга ёс,
- Хэрэглэгч үйлчлүүлэгчдийн эрх ашиг,
- Нийгмийн оролцоо ба хөгжил.

19. Даян дэлхийн гэрээ - Global compact United Nation: Даян дэлхийн гэрээ санаачилгыг НҮБ-аас санаачлан бизнесийн байгууллагуудыг үйл ажиллагаагаа явуулахад тогтвортой хөгжлийн дагуу нийгмийн хариуцлагатай байхад нь туслах зорилгоор хийгдэж анх 1999 оны Дэлхийн эдийн засгийн чуулганаар анх олон нийтэд танилцуулагдаж байсан. Өдгөө эгнээндээ 170 улсын 13000 компанийг нэгтгэсэн тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хамгийн том сүлжээ байгууллага болоод байна. Хамрах хүрээ:

- Бизнесийн үйл ажиллагаа нь ОУ-д мөрдөгддөг хүний эрхийг хүндэтгэх, хамгаалахыг дэмждэг байх,
- Хүний үндсэн эрхийн асрэг ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй байх,
- Бизнесийн үйл ажиллагаа нь хүмүүсийн эрхээ хамгаалахаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд дэмждэг үзүүлдэг байх,
- Бүх төрлийн албадлагын хөдөлмөр эрхлэлтийг зогсоох,
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг зогсоох,
- Ажилтнууд болон ажил мэргэжил дээрх ялгаварлан гадуурхалтыг зогсоох,
- Бизнесийн үйл ажиллагаа нь байгаль орчинд тулгарч буй сорилтоос урьдчилан сэргийлэх хандлагыг дэмждэг байх
- Байгаль орчны хариуцлагыг сайжруулах санаачилгыг хариуцан авах,
- Байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэхийг урамшуулах,
- Бизнесийн үйл ажиллагаа нь хээл хахууль, авлигын эсрэг чиглэсэн байх.

20. ОУ-ын Нийгмийн хариуцлага 8000 - Social Accountability International 8000, 2008: ОУ-ын Нийгмийн хариуцлага 8000 нь сайн дурын сертификатжуулалтын стандарт бөгөөд анх АНУ-ын Нийгмийн хариуцлагын ОУ-ын байгууллагаас үйлдвэрчний эвлэл, ТББ-тай хамтарч 2001 онд боловсруулагдаж 2004, 2008 онуудад сайжруулсан байна. Хамрах хүрээ:

- Хүүхдийн хөдөлмөр,
- Хүч хэрэглэсэн албадлагын хөдөлмөр,
- Эрүүл мэнд ба аюулгүй байдал,

- Эвлэлдэн нэгдэх, үг хэлэх эрх чөлөө,
- Ялгаварлан гадуурхалт,
- Ажлын цаг,
- Нөхөн төлбөр,
- Менежментийн систем.

21. Байгалийн баялгийн тунхагийн The Natural resource charter benchmarking framework. Байгалын баялгын засаглалын хүрээлэн, 2017.

- Стратеги, завшил, институци
- Хариуцлага, ил тод байдал
- Хайгуул, лиценз олголт
- Татвар хураалт
- Орон нутгийн үр нөлөө
- Үндэсний өмчит баялгын компани
- Орлогын хууваарилалт
- Орлогын савалгаа
- Засгийн газрын зарцуулалт
- Хувийн хэвшлийн хөгжил
- Үндэстэн дамнасан компаниудын үүрэг
- Олон улсын хамтын нийгэмлэгийн үүрэг

22. Уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглал, хүний эрхий талаарх даян дэлхийн удирдамж.

- Нөөцийг хамгаалах сан байгуулах: Стратеги, хөрөнгө оруулалтын бодлого, бодлого ба хууль тогтоомж.
 - Ашигт малтмалын ордын эзэмшил, хувь жишгийг бий болгох.
 - Тэргүүлэх ордын талаар баримтлах стратеги боловсруулах, олборлолтын гийт зардал болон ашгийг харгалзан үзэх.
 - Хариуцлагатай уул уурхайд хөрөнгө оруулалтыг татах нь хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах нь.
 - Зохих бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх нь.
 - Байгууллагуудыг дэмжиж, чадавхийг бэхжүүлэх нь.
 - Мэдээлэл авах, тэгш оролцоо, шудрага ёсны хүртээмжийг өөхжүүлэх нь.

- Мэдээлэл авах
- Тэгш оролцох боломж
- Шудрага ёсны хүртээмж
- Хайгуулаас уурхайн хаалт хүртэлх олборлолтын үеийн оролцооны төлөвлөгөө
 - Уул уурхайд тохиромжтой газар нутгийг тодорхойлохын тулд оролцоог хангасан, нэгдмэл байдлыг эрхэмлэсэн газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах нь.
 - Уугуул иргэдийн газар нутагт уул уурхайг төлөвлөхдөө тэдний эрхийг хангахад анхаарах.
 - Газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулахдаа эмэгтэйчүүдийн эрхийг хангахад анхаарах нь.
 - БОНСУ-ний төлөвлөлтийн аргыг ашиглах нь
 - Бүс нутгийн болон орон нутгийн төлөвлөлтийн зөрүүтэй байдлыг арилгах нь.
 - Хаалтын төлөвлөгөөг газар ашиглалтын төлөвлөгөөний нэг хэсэг болгох нь.
- Хайгуул
 - Хайгуулийн үед БОНХЭ-ийн асуудлын шийдвэрлэх нь
 - Олон нийт болон оролцогч талуудыг татан оролцуулах нь.
- Техник эдийн засгийн үндэслэл ба тусгай зөвшөөрөл
 - Хуульд юу заасан ба заагаагүйг ойгож мэдэх нь
 - Хөрөнгө оруулалт хийх компанийг танин мэдэх нь
 - Компанийн зорилгыг танин мэдэх нь
 - Тусгай зөвшөөрөл, гэрээнд юу тусгагдсаныг ойлгож мэдэх нь
 - Уул уурхайн үйл ажиллагаа явагдах газрын орон нутгийн онцлогийг ойгож мэдэх нь
- Хөгжил ба бүтээн байгуулалт
 - Барилгын үед БОНХЭ-ийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавих
 - Олон нийтийн оролцоог зохицуулах
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - Үйлдвэрлэлийн үеийн БОНХЭ-ийн шаардлагуудыг шинэчилэх
 - Үйлдвэрлэлийн үеийн БОНХЭ-ийн нөлөөлөлд тогтмол хяналт тавих
 - БОНХЭ-ийн нөлөөллийн явцыг хянах

- Хаалт
 - Хаалтын болон хаалтын дараахь байдлыг цогц аргаар төлөвлөх
 - Оролцогч талуудыг хаалтын үйл явцын гол хэсэг болгон оролцуулах
 - Нарийн тохируулагатай хаалтын ажиллагаа олон хаалтын дараах үеийн хандлагад нөхөн сэргээлтийн мониторинг хийх
- Хаалтын дараахь үе
 - Хаалтын үеийн БОНХЭ-ийн нөлөөллийг хянах
 - БОНХЭ-ийн зорилтуудыг хүлээлгэн өгөх нөхцөлд оруулах
 - Орхигдсон, эзэнгүй уурхайг манлайлах үүрэг хүлээх нь
- Хөндлөн огтлолцол: Хууль сахиулах, шудрага ёс тогтоох, гомдол шийдвэрлэх механизм
 - Хууль сахиулах байгууллага
 - Оролцогч талуудын шудрага ёсны хүртээмж
 - Уул уурхайн компаниудын үйл ажиллагааны түвшний гомдол шийдвэрлэх механизм.

23. Сул засаглалтай орчинд ажиллаж буй үндэстэн дамнасан компаниудад зориулсан ЭЗХАХБ-ын эрсдлийг үнэлэх арга хэрэгсэл – The OECD Risk awareness tool for multinational enterprises in weak governance zones. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага, 2006 он.

Сул засаглалтай орчин нь гэдэг нь засгийн газар нь хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй, эсвэл хүлээдэггүй хөрөнгө оруулалтын орчин юм. Энэхүү "Засгийн газрын бүтэлгүйтэл" нь улс төр, эдийн засаг, иргэний нийгмийн байгууллагуудад хүртэл шууд нөлөөлдөг өргөн хүрээг хамардаг бөгөөд энэ нь эргээд хүчирхийлэл, гэмт хэрэг, авилга, эдийн засаг, нийгмийн хөгжилд саад учруулдаг тул дэлхийн нийтийн тогтвортой хөгжлийн төлөөх санаачилга мөн. Хамрах хүрээ:

- Хуулийг сахин биелүүлэх ба олон улсын сайн туршлага, арга хэрэгслийг ашиглах нь,
- Компанийн удирдлага, менежментэд анхаарал хандуулах нь,
- Улс төрийн үйл ажиллагаа,
- Бизнесийн хамтрагч, үйлчлүүлэгчээ сайн мэдэх,
- Буруу үйлдлийг хэлэх, сануулах,

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

- Сул засаглалтай нийгэмд өөрийн ашиг сонирхлыг өргөн цар хүрээнд харах,

Хүснэгт 3. Хамгийн чухал хамааралтай ХУУ-н санаачилгуудын давуу ба сул тал

Нэр	Давуу тал	Сул тал
Хариуцлагатай уул уурхайн стандарт 2.0 хувилбар. IRMA. 2012	Дэлгэрэнгүй, УУ менежментийн толь, хүний эрх, БО-ны шаардлага өндөр, эерэг өв соёл, цаг уурын өөрчлөлт.	Эхлээгүй, арагчлал дуусаагүй. Онлайн санал.
Хариуцлагатай уул уурхайн индекс. RMI Foundation. 2014	Харьцангуй дэлгэрэнгүй. Эдийн засгийн үр өгөөж, корпорацийн бүтэц-бизнесийн уялдаа, ирээдүйн хөгжил. Онлайн санал, 8 оронд хэлэлцүүлсэн. МУ-аас ОТ орно. Уурхайн түвшний үзүүлэлт.	Эхлээгүй, арагчлал дууссан. БО, ХАБАЭ-ийн шаардлага дэлгэрэнгүй биш.
БО, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт. IFC. 2012	Нөөцийг дуустал ашиглах технологи, газар эзэмшил, суурьшуулалт, соёлын өвийг хамгаалах. ХО татах. Эрсдлийн үнэлгээний аргачлал.	БО-ны хамгаалалтын шаардлага. Эдийн засгийн үр өгөөж.
Тогтвортой уул уурхай руу. TSM 2004.	2004 оноос эхэлсэн. Хэд хэдэн удаа шинэчилэгдсэн. Олон нийтийн оролцоог чухалчилсан. Олон нийтийн зөвлөх хороогоор баталгаажуулдаг.	Зэрэглэл тогтоодог өндөр нарийвчилсан шаардлагатай.

ХУУ-н үнэлгээний хэрэглээ ба ялгаатай байдал

Дээрх бүгд дотоодын болон олон улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн санаачилгуудын шаардлагуудыг харьцуулан харьцуулсан шинжилгээ боловсруулсан. Үүнээс харахад ХУУ-н үнэлгээний хэрэглээний хувьд Европ тивийн улс орнууд судалгаанд авч үзсэн 23 санаачилгаас 10 буюу нийт 44 хувийг өндөр хөгжилтэй орнууд, банк санхүү, хөрөнгө оруулалтын сангууд байршдаг улс орнууд эзэлж байна. Канад болон Австралийн уул уурхайн холбоод болон гишүүн байгууллагууд нь хариуцлагатай уул руухай гэхээсээ илүүтэйгээр эрсдлийн менежментийн

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

үнэлгээг хийдэг ба ихэнхи улс орнууд хэн ямар зорилгоор, ямар үр дүнд хүрэхийн тулд хэрэглэж байгаагаас шалтгаалан доорхи 4 төрлөөр хэргэлэгдэж байна. Үүнд:

1. Баталгаажуулалт

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг баталгаажуулах (сертификат) сайн туршлагыг түгээх.

2. Санхүүгийн эрсдэл

Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сангууд, зээлийн эрсдлийг бууруулах.


3. Компанийн үнэ цэнэ

Уул уурхайн ассоциаци, мэргэжлийн холбоод, гишүүдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, зөвлөн туслах.

4. Шагнал

Шилдэг уурхай, уул уурхайн салбарын компанийг шалгаруулах.

Зураг 4. ХУУ-н сайн туршлагуудыг дэлхийн газар зүйн байршлаар харуулбал:



ХУУ-г хэрэгжүүлэх хөшүүрэг

Уул уурхай туршлагатай ихтэй улс орнууд тэр дундаа Канад, Австралийн компани, мэргэжлийн холбоод ХУУ-г эрсдлийн менежмент гэж үздэг тухай дээр дэлгэрэнгүй дурьдсан. Тэгвэл компаниуд хариуцлагатай ажиллахын ач холбогдлыг дараахь байдлаар ялган гаргалаа.

1. Стратеги, менежментийг хөгжүүлэх

- Үр дүнтэй, хэмжиж болохуйц гүйцэтгэл, төлөвлөлт
2. Урт хугацааны тогтвортой орлогыг нэмэгдүүлэх
Өрсөлдөх давуу тал ба зардал буурах, хэмнэх.
 3. Ажилтны өндөр бүтээмж
Ажилтны сэтгэл ханамж, ёс зүйн асуудал, мэдлэг туршлага хуримтлагдах.
 4. Ирээдүйн төслийн хөрөнгө оруулалт
Компанийн сайн туршлага, мэдлэг, зээлийн түүх, нэр хүнд.
 5. Зөрчлийн өртгөөс сэргийлэх
Олон нийт, оролцогч талуудын дэмжлэг

ХУУ-н талаарх оролцогч талуудын ойлголт

Хариуцлагатай уул уурхайн шаардлага, үнэлгээний аргачлалын талаар МХЕГ, АМГТГ, УУХҮЯ, уул уурхайн холбоо, иргэний нийгмийн байгууллага, уул уурхайн компаниудтай зөвлөлдөж оролцогч талуудын санал, зөвлөмжийг сонсохоос гадна хариуцлагатай уул уурхайн талаарх тэдний төсөөллийг олж мэдэхийг зорьсон болно.

Уул уурхайн салбарын хариуцлагыг бүрэн дүүрэн илэрхийлэхүйц зөв системтэй ойлголтыг гаргах, зарчим, хамрах хүрээг тодорхойлох, хариуцлагын түвшинг хэмжих боломжит шаардлагууд, үзүүлэлтийг боловсруулснаар төрийн болон төрийн бус байгууллага олборлох салбарын үйл ажиллагааг сайжруулахдаа хэрэглэх шаардлагуудыг гаргаж, түүний дагуу хянаж сайжруулснаар эрдэс баялгийн салбар нь зөв замаар хөгжиж байгаа эсэхэд хяналт тавих, сайжирч эсвэл муудаж байгааг харуулах боломж бүрдэнэ гэдгийг уулзалдаж, зөвлөлдсөн бүхий л оролцогч талууд хүлээн зөвшөөрч байсан боловч хариуцлагын талаарх ойлголт бүрэн дүүрэн биш байгааг анзаарав. Өөрөөр хэлбэл хариуцлагын тухай ойлголт сөрөг утга илэрхийлдэг гэж үзэх төрийн байгууллагын төлөөлөл, мөн зарим иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл олон байсан. Харин зарим компани, тэр дундаа төрийн өмчийн компанийн оролцогчид уурхай хариуцлагагүй ажиллавал хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй компанийн хувьд зардал, өртөг нь нэмэгддэг, ирээдүйн боломжит ашгийг хүртэх боломжоо алддаг талаархи ойлголт сул байсан тул судалгаанд эдгээр ойлголтуудын талаар товч байдлаар тусгах болсон. Монголын маркетингийн холбооны тэргүүн, уул уурхайн

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

ложистикийн Терра экспресс компанийн үүсгэн байгуулагч Н.Алтанбагана захирлын хэлснээр “Хариуцлага гэхээр хүмүүсийн чихэнд албадлага, дарамт гэж хүлээж авч, хийх дургүй байдаг тул энэ ойлголтыг эерэг утгатай болохыг ойлгуулах нь чухал” гэдэг зөвлөгөө их чухал санагдсан. Компани гэдэг бол хүмүүсээс бүрддэг, хүн л шийдвэр гаргадаг гэдгийг судалгааны явцдаа хүний хүчин зүйлийг тооцож, компанийн ашиг сонирхол нь хариуцлагатай уул уурхайн шаардлага, зарчимтай огтлолцож байвал ХУУ бодит байдал дээр хэрэгждэг гэдгийг олон улсын туршлагыг судлах явцад олж мэдсэн болно.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын БОГУУХУГ-ын дарга Н.Батбаяр, Ашигт малтмал, газрын тосны газрын Хүнд үйлдвэр, техник технологийн хэлтсийн дарга Г.Тамир, МХЕГ-ын Байгаль орчин, газар геодези хариуцсан улсын байцаагч Б.Энхгэрэл, Монголын уул уурхайн ассоциацийн Гүйцэтгэх захирал Д.Энхболд нартай уулзалт ярилцлагын үеэр ХУУ-н шаардлагад ил тод байдал, байгаль орчны нөлөөлөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, орон нутгийн иргэдийн оролцоо ба хөгжлийн талаар шаардлагууд байх нь зүйтэй гэдгийг санал болгохоос гадна компаниудыг хэрхэн хариуцлагатай, сэтгэлтэй үйл ажиллагаа явуулах вэ, компаниуд үүнийг хэрэгжүүлэх хөшүүргэ нь юу байх вэ, төрийн байгууллагын зүгээс дангаараа хүчрэхгүй, хүний нөөц, санхүү дутагдалтай байдгийг онцолж байсан. МХЕГ-ын зүгээс хяналт шалгалт хийх явцад тулгардаг гол бэрхшээл болох хуулиар хийхийг шаардсан баримт бичгийг шалгахад зориулан үзүүлдэг цаас төдийгээр үзэж, хэрэглэгддэггүй байх тохиолдол их байдгийг үнэлгээний аргачлалдаа тусгахыг зөвлөж байсан. МХЕГ-ын зүгээс ХУУ-н шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх, зорилго, ач холбогдлыг юу гэж харж байгаа талаар асуухад МХЕГ нь уул уурхайд мөрдөгддөг хууль, журмын заалтыг хэрэгжүүлэх, заавал мөрдөх MNS стандартын дагуу нийцлийн хяналт хийдэг тул ХУУ-н шаардлагыг өөрсдийн ажил, Монгол Улсын уул уурхайн бодлого, хууль, стандарт, хөтөлбөрт санал өгч сайжруулах зорилгоор ашиглана гэсэн төсөөлөлтэй байгааг илэрхийлж байсан. Харин Монголын Уул уурхайн ассоциацийн хувьд олборлох салбарын компаниудын том болон дунд компаниуд уул уурхайн салбарын нийт төсвийн орлогын 80 орчим хувийг бүрдүүлдэг гэтэл дунд жижиг, жижиг компаниуд хариуцлагагүй ажилласнаар нийт уул уурхайн компаниудын нэр хүндийг унагах, байгаль орчныг сүйтгэх, орон нутгийг иргэдийн эрх ашгийг үл хүндэтгэх, буруу жишиг тогтоох нь илүү байгаа тул тэдгээр компаниудыг хариуцлагажуулах, боломжийн ажиллаж байгаа

компаниудаа илүү сайжруулах, стратеги, менежментийн арга хэрэгсэл болгон ашиглах боломжтой гэдгийг хэлж байсан. Мөн УУХҮЯ, БААЖЯ болон АМГТГ-ын удирдлагууд уул уурхайн салбарын бодлого, хуулийг сайжруулах ач холбогдолтой байж болохыг тус тус хэлж зөвлөж байсан.

3.4 Хариуцлагатай уул уурхайн харьцуулсан шинжилгээ, үр дүн

Монгол Улсын төрийн болон ТББ-д, банк санхүүгийн байгууллага судлаачдын хариуцлагатай уул уурхайн туршлагыг харуулах санаачлагуудын хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг Олон улсын хариуцлагатай уул уурхайн санаачилгуудтай харьцуулж хамрах хүрээг компанийн үйл ажиллагааны нөлөөлөл, экологийн ул мөрийн дагуу шаардлагуудыг гаргах зорилготойгоор чухлын дарааллыг тогтоох ач холбогдолтой харьцуулалтыг боловсрууллаа.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

Хүснэгт 4. Хариуцлагатай уул уурхайн санаачилгуудын харьцуулалт

№	Стандартын нэр	Байгууллага	"1" тэмдэглэгээ нь тухайн санаачилгын холбогдох дэд бүлгүүдээс хамгийн багадаа нэг асуудлаас иш татсан байдлыг илэрхийлнэ	Нэмэлт
			<p>Олон талын оролцоог хангах</p> <p>Ил тод, нээлттэй байх</p> <p>Хуулийг сахин дээдлэх</p> <p>БО, хүний аюулгүй байдлын өмнө</p> <p>Хариуцлага хүлээх</p> <p>Ирэдүйн хөгжилд хөрөнөг оруулах</p> <p>Үр өгөөжтэй байх</p> <p>Хүмүүнлэг ёс зүйтэй байх</p> <p>Дэвшилтэд технологид суурилсан байх</p>	
Хариуцлагатай уул уурхайн Монгол Улсын туршлага				
1	"Хариуцлагатай уул уурхайн гарын авлага" - Responsible Mining Guideline, 2017 он.	НҮБХХ, ИБУИНВУ-ын ЭСЯ, Хариуцлагатай уул уурхайн санаачлага ТББ.	<p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p> <p>1</p>	Тус гарын авлага нь өмнөх бүлэгт дурдсан 8 зарчмыг хэрэгжүүлэхэд шаардагдах шаардлагуудаас гадна уул уурхайн амьдралын мөчлөгт бий болдог үйл явцыг энгийн ойлгомжтой хэлбэрээр нарийвчлан тайлбарласан.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

2	"Хариуцлагатай уул уурхай" сургалтын гарын авлага - "Responsible mining" Training manual, 2016.	НҮБХХ, Австралийн Квинсландын Их Сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн Иргэний Бодлогын шийдэл судалгааны хүрээлэн.	1	1	1	1	1	1	1	Гарын авлага учир ойлголтуудыг сайжруулах тайлбаруудтай. Усны зүй зохистой хэрэглээ, уул уурхайн нөхөн сэргээлтийг тусад нь оруулсан.
3	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга - Extractive Industries Transparency Initiative. 2006	ОУИТБС ОУБ, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба	1	1	1	1	1	1	1	Компаниудын уул уурхайн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн, санхүүгийн дэлгэрэнгүй мэдээлэл, бенефициар өмчлөгчийн тухай мэдээлэл. ТУЗ болон засаглалтай холбоотой мэдээлэл.
4	Монгол Улсын тогтвортой санхүүжилт (ТОС)-ийн зарчим Уул уурхайн салбарын удирдамж. 2015.	Монголын банкуудын холбоо.	1	1	1	1	1	1	1	Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих, Манлайлан үлгэрлэх зэрэг хүрээ нь санхүүгийн зээл олгоход шаардлагатай эрсдлийг багтаасан.
5	Усны менежментийн практик Үйл ажиллагааны сайн дурын кодекс - Voluntary code of practice: Minerals Industry and water management	Монголын уул уурхайн 10 компанийн санаачилга, ОУВС	1	1	1	1	1	1	1	Усыг зүй зохистой хэрэглэх санаачлага гаргах, бүтээмжийг нэмэгдүүлэх.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Хариуцлагатай уул уурхайн олон улсын туршлага										
6	Хариуцлагатай уул уурхайн стандарт - IRMA Standard for Responsible Mining IRMA-SDT-001 Draft v2.0, 2016	"Хариуцлагатай уул уурхайн санаачилгын баталгаажуулалт" ОУ-ын мэргэжлийн байгууллагуудын эвсэл.	1	1	1	1	1	1	1	ISO 26000-ийн 7 хүрээг бүхэлд нь оруулсан бөгөөд нэмэлтээр бизнесийн уялдаа холбоо, байгаль орчны хариуцлага, эерэг туршлага өв үлдээх төлөвлөлт, удирдлагын талаар орсон. Уур амьсгалын өөрчлөлт ба засаглал дотоод хяналтын асуудал.
7	Хариуцлагатай уул уурхайн Индексийг тооцох аргачлалын төсөл - Responsible mining index draft methodology.	Хариуцлагатай уул уурхайн сан. 2014	1	1	1	1	1	1	1	Усны зүй зохистой хэрэглээг БО-ны асуудлаас тусад нь ялган оруулсан. Уурхайн амьдралын мөчлөгт тохируулсан менежментийн арга барил. Эерэг өв уламжлал үлдээх болон ХАБАЭ чухалчилан, дотоод менежментийн арга хэрэгсэл.
8	ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт - IFC Performance Standards on Environmental and Social Sustainability, 2012.	ОУВС	1	1	1	1	1	1	1	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн үнэлгээ хийх, Газар эзэмшил болон сайн дурын бус дахин суурьшуулахыг эв зүйгээр шийдвэрлэх. Соёлын өвийг хамгаалах.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

9	Тогтвортой уурхайн төлөө - Towards sustainable mining. 2004.	уул	Канадын Уул Уурхайн Холбоо	1	1	1	1	1	1	1	1	1	Сайн дурын тайлан. Хямралын эсрэг менежментийн төлөвлөгөө, хүдрийн хаягдлын менежмент, Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн менежмент.
10	Уул уурхайн металлын ОУ-ын зөвлөлийн зарчим - ICMM principles	10	Уул уурхай металлын ОУ-ын зөвлөл	1	1	1	1	1	1	1	1	1	Компанийн засаглал, ёс зүйтэй бизнесийн туршлага, эрсдэлийн менежментийн стратегийг хэрэгжүүлэх, 3R зарчмыг хэрэгжүүлэх.
11	Уул уурхайн тогтвортой хөгжлийн замын зураг: Atlas - Mapping Mining to the Sustainable Development Goals: An Atlas, 2016.	Уул уурхайн хөгжлийн замын зураг: Atlas - Mapping Mining to the Sustainable Development Goals: An Atlas, 2016.	Дэлхийн эдийн засгийн форум, НҮБХХ, Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой хөрөнгө оруулалтын Колумбия төв.	1	1	1	1	1	1	1	1	1	Цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, хүлэмжийн хийг бууруулах, Тэгш оролцоог хангах, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх. Орон нутгийн иргэдийн эрхийг дээдлэх, Ханган нийлүүлэлтийн бодлогоороо зохистой хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх.
12	Экваторын санаачилга - The Equator Principles, 2013.	Экваторын санаачилга - The Equator Principles, 2013.	Экваторын санаачилга. АНУ	1	1	1	1	1	1	1	1	1	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын институциудад зориулсан. Шаардлагуудыг төрөлжүүлэн сонгодог. Зарчмуудын дагуу төлөвлөгөө боловсруулж түүнийгээ тайлагнадаг. Хараат бус тайлан гаргах.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

13	Нийгэм, эдийн засгийн аргачлал - Social Economic Assessment Toolbox, 2012.	АнглоАмерикан ХК	1		1	1	1	1	1	1	Нийгэм, эдийн засгийн үнэлгээ хийх дараалал.
14	Зүүн өмнөд азийн бус нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг ASEAN -ын олборлох үйлдвэрлэлийн засаглалын хүрээ. - ASEAN Framework for extractive industries governance in ASEAN, 2014.	ASEAN	1	1	1	1	1	1	1	1	Засаглалын тогтолцоо, дотоод хяналтын тогтолцоо, усны асуудал ба уур амьсгалын өөрчлөлт. ХАБАЭ-ийн асуудал ба ил тод, ёс зүйтэй бизнесийн харилцаа. Хүний эрх хөдөлмөр эрхийг тусгасан.
15	СССМС-ын гадаадын уул уурхайн салбарт хөрөнгө оруулахад баримтлах КНХ-ын гарын авлага	Хятадын эрдэс баялаг, химийн бүтээгдэхүүн импортлогч экспортлогчдын худалдааны тэнхим. 2014			1	1	1	1	1		Байгууллагын засаглал, Шударга үйл ажиллагаа, Үнэ цэнийн гинжин хэлхээг бий болгох менежмент.
16	Хариуцлагатай эрдэс баялгийн хөгжлийн санаачилга - Responsible Mineral Development Initiative, 2011.	Дэлхийн эдийн засгийн форум	1	1						1	Оролцогч талуудыг чадавхжуулах, нэгдсэн ойлголттой болохыг чухалчилсан. Уул уурхайн амьдралын мөчлөгийн үе шатуудад оролцогч талуудын оролцоог хангах. Урьдчилсан ТЭЗҮ-ийн шатанд

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

17	Тайлагналын ОУ-ын санаачлага - GRI	Global reporting initiative 2014	1	1	1	1	1	1	1	эрсдэлийг тооцож эхлэх. Хүний эрх ба хөдөлмөрийн эрх.	Шударга өрсөлдөөний тайлан, Худалдан авах ажиллагааны тайлан, Бараа материал, хэрэглээний тайлан, эрчим хүч, ус, биологийн төрөл зүйл, хорт хий ялгаруулалтын тайлан, ханган нийлүүлэгчдийн байгаль орчин нийгмийн үнэлгээний тайлан, тэгш боломж, ялгаварлан гадуурхалтын тайлан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тайлан, бодлогын баримт бичгийн тайлан, хэрэглэгчийн эрүүл мэнд болон аюулгүй байдлын тайлан.
18	ISO 26000 - Нийгмийн харуцлагын удирдамж - Social responsibility guidelance, 2010.	Олон улсын стандартын байгууллага. Стандарт хэмжил зүйн газар.	1	1	1	1	1	1	1	Байгууллагын засаглал, үндсэн эрхийг чухалчилсан. Бүх салбарт хэрэгжүүлж болох суурь шаардлагуудыг багтаасан ХАБАЭ, .	

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

19	Даян дэлхийн гэрээ - Global compact	НҮБ	1	1	1	1	1	1	Бизнесийн үйл ажиллагаа нь ОУ-д мөрддөг хүний эрхийг хүндлэх, хамгаалдаг байх, Бизнесийн үйл ажиллагаа нь хүмүүсийн эрхээ хамгаалахаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд дэмжлэг үзүүлдэг байх, Хүүхдийн хөдөлмөр, ялгаарлан гадуурхалтгүй байх, Авлигын эсрэг чиглэсэн байх, Байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, санаачилгыг урамшуулах.
20	ОУ-ын Нийгмийн хариуцлага. Social Accountability International, 2008.	Нийгмийн хариуцлага Интернэйшонал. АНУ	1				1	1	Ажилчдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрхийг баталгаажуулахад илүү чиглэгдсэн. Хүүхдийн хөдөлмөр, Эвлэлдэн нэгдэх үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулах, Ялгаарлан гадуурхалт, дарамт хэлмэгдүүлэлтийг түлхүү тусгасан байна.
21	Байгалийн баялгийн тунхагийн The Natural resource benchmarking framework. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, 2017.	Байгалийн засаглалын баялгийн хүрээлэн.							Байгалийн баялгийн засаглал, Орлогын тэгш хуваарилалт ба баялгийн орлогын зөв зарцуулалт. Хүний эрх хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрхүүд. Засаглалын асуудал ба хяналттай иргэдийн оролцоо.

**ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**


22	Уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглал, хүний эрхийн талаарх даян дэлхийн удирдаж	НҮБ	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	Хүний үндсэн эрх, аюулгүй амьдрах. Эдийн засгийн урт хугацааны үр өгөөж ба уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэлтүүд. Эрчим хүчийг хэмнэх нөөцийн хэрэглээг багасгах. Засаглал ба ил тод байдлын тухай асуудлууд.
23	Сул засаглалтай орчинд ажиллаж буй үндэстэн дамнасан компаниудад зориулсан ЭЗХАХБ-ын эрсдлийг үнэлэх арга хэрэгсэл – The OECD Risk awareness tool for multinational enterprises in weak governance zones.	ЭЗХАХБ OECD	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	Засаглал, бизнесийн ёс зүйтэй холбоотой эрсдлийн үзүүлэлтүүд, Ил тод байдал иргэдийн оролцоог хангаж БО, ХАБАЭ-ийн арга хэмжээний эрсдлийг үнэлэх. Эдийн засгийн үр өгөөжөө хамтдаа хүртэх.
	Нийт		12	4	11	7	10	9	6	Нийт 23 санаачлага								

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмыг олон улсын санаачилгуудын зарчим, хүрээтэй харьцуулахад компанийн өөрийн сонголтоос бий болдог ул мөр нь байгаль орчны хамгаалалт (17 балл), ХАБАЭ (16 балл), засаглал (15 балл), хүний эрх ба хөдөлмөрийн харилцаа (15 балл), дотоод хяналт (13 балл), орон нутгийн харилцаа ба хамтын ажиллагааны гэрээ (15 балл), усны нөөцийг зохистой ашиглах (13 балл)-тай холбоотой хамрах хүрээ, шаардлагууд хамгийн их иш татагдсан байна.

Олон талын оролцоог хангах, ил тод нээлттэй байхтай холбоотой хамрах хүрээ, шаардлагууд нь (12 балл) уурхайн амьдралын мөчлөг ба бүлэг бүрт ажиллах зарчим байдлаар тусгагдсан байсан. Үүнийг графикаар харуулбал:

График 19. Хариуцлагатай уул уурхайн хамрах хүрээ, шаардлагуудын хамгийн их иш татагдсан байдал



Олон улсын туршлагад байх дээрх хамрах хүрээ, шаардлагуудыг эрсдлийн удирдлагын дагуу эрсдлийг бүлэглэн ангилсан гэж хэлж болно. Монгол Улсын хариуцлагатай уул уурхайн туршлагатай харьцуулахад шинэ ойлголтууд нь ашиг хүртэгч эзэн, эерэг өв үлдээх, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шаардлагууд байсан. Мөн бидний хэрэглэж байгаа зарчим хэмээх ойлголт нь олон улсын санаачлагуудад ажиллах зарчим ба хамрах хүрээ гэж ангилсан

байна. Principle буюу зарчим нь үнэт зүйлстэй холбоотой ойлголт бөгөөд ардчилсан засаглал сайтай ХБНГУ, Канад, Норвеги, Австрали, АНУ зэрэг орнуудын түгээмэл хэрэглэдэг санаачлагуудад ардчилалын үнэт зүйл болох олон нийтийн оролцооны зарчим, ил тод байх зарчим зэргийг тусгайлан хамрах хүрээ болгон оруулаагүй харин бүхий л хамрах хүрээнд орох шаардлагуудад тусгасан байсан.

Усны зохистой хэрэглээ, хог хаягдлын менежменттэй холбоотой шаардлагууд Монгол Улсын дотоодын санаачилгуудад байгаль орчин, хүний аюулгүй байдлыг хангах зарчимд багтсан байх боловч олон улсын санаачилгаар үүнийг тусад нь бие даасан байдлаар оруулсан байгаа нь илүү чухалчлан авч үзэх шаардлагатай болохыг харуулсан байна. Мөн засаглал бизнесийн ёс зүйтэй холбоотой шаардлагууд ил тод байх болон хүмүүнлэг ёс зүйтэй байх зарчимд туссан байх боловч байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм журамд суусан эсэх шаардлагууд багтаагүй байсан бөгөөд энэ нь байгууллагын засаглал нь тухайн уул уурхайн компанийг зөв үйл ажиллагаа явуулахад эрх мэдлийн хуваарилалт чухал үүрэгтэй болохыг харуулж байна. Хүний эрх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой шаардлагууд нь уул уурхайн салбар нь олон тооны ажилтантай салбарын хувьд зайлшгүй тавигдах шаардлага болохыг харуулсан. Ялангуяа эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэлтэй холбоотой шаардлагуудыг багтаасан зайлшгүй багтаасан байсан.

Компанийн хариуцлагыг үнэлэдэг өөр нэг төстэй үйл ажиллагаа бол төрийн хяналт шалгалт гэж үзэж болно. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 2003 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад эрх олгосон эрх зүйн баримт бичгийн дагуу төрийн зүгээс хуулийн хэрэгжилт ба хуулийг дагаж гарсан дүрэм, журам, тушаал мөн түүнчлэн заавал дагаж мөрдөх MNS стандартуудын дагуу эрсдлийн үнэлгээ хийж, үнэлгээнд үндэслэн төлөвлөгөөт хяналт шалгалтын дагуу батлагдсан хяналтын хуудасаар хяналт шалгалт хийдэг.

Хүснэгт 5. МХЕГ-ын хяналтын хуудасны хамрах хүрээ, шаардлагуудын харьцуулалт

1	Ажилтны нийгмийн хамгаалал ба эрүүл мэнд
2	Ажилтны нийгмийн даатгал, тэтгэмж

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

3	Дотоод хяналтын зохицуулалт
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
5	Хөдөлмөрийн харилцаа ба цалин
6	Лиценз, зөвшөөрөл, баталгаажуулсан байдал
7	БО-ны бохирдол, хамгаалалт
8	Нөөцийн ашиглалт тооцоо, төлбөр
9	Химийн, аюултай, тэсрэх бодистой холбоотой зохицуулалт
10	Барилга байгууламжийн стандарт
11	ТЭЗҮ-ийн дагуух зураг төсөл
12	Боловсруулалтын технологи
13	Газар ашиглалт ба төлбөр

МХЕГ-ын хяналтын хуудасны харьцуулалтаас харахад байгаль орчны хамгаалалт, ХАБАЭ-ийн хэрэгжилт, ажилтны эрүүл мэнд ба нийгмийн даатгалтай хобоотой харилцаанууд, үйлдвэрлэлийн технологийн горим, барилга байгууламжийн зураг төсөл, газрын төлбөртэй холбоотой шаардлагууд илүү зонхилох боловч засаглал, хүний эрх, хөдөлмөрийн харилцаа, эдийн засгийн үр өгөөж, орон нутгийн хөгжил, ирээдүйн хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хамрах хүрээ, шаардлагуудыг багтаагаагүй байна. Мөн хяналтын хуудасны шаардлагуудын 83% нь нийцлийн, 17% нь гүйцэтгэлийн хяналт шалгалтын шаардлагууд давамгайлсан байна.

Хүснэгт 6. МХЕГ-ын хяналтын хуудасны нийцлийн болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн харьцаа

Нийцлийн хяналт шалгалт	83 %
Гүйцэтгэлийн хяналт шалгалт	17 %

Судалгааны үр дүнд гарсан шаардлагуудыг дараахь 5 бүлэгт хуваан тэдгээрт хамаарах зайлшгүй оруулах шаардлагуудыг гаргасан болно. Үүнд:

1. Компанийн сайн засаглал ба ил тод байдал

Ил тод байх мэдээлэл, ХО-ын гэрээний нөхцөл, татвар, тайлан, санал гомдлын механизм, ёс зүйн код ба дотоод хяналтын механизм,

2. Хүний эрхийг хангах ба хөдөлмөрийн харилцаа

Хүний үндсэн эрх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, эрхээ хамгаалуулах эрх, тэгш боломж, шудрага хөдөлмөр, сурч боловсрох хөгжих боломж ба цомхотгол.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэнд

Аюултай үзэгдэл, эрсдлийн үнэлгээ ба илрүүлэлт, хяналт, урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрхэн төлөвлөн гүйцэтгэх, компанийн аюулгүй ажиллагааны дотоод соёл.

4. Байгаль орчны хамгаалалт

БОНБУ, ус, агаар, хог хаягдал, дуу чимээ, хүлэмжийн хийн ялгарал, биологийн олон янзын байдал ба дүйцүүлэн хамгаалалт уурхайн хаалт.

5. Орон нутгийн хөгжил ба олон нийтийн оролцоо

Улс, аймаг, сумын татвар төлбөр төлөлт, тогтвортой ажлын байр, төсөл хөтөлбөр, дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба ирээдүйн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны бодлого, хамтын ажиллагааны гэрээ, мөнгөн болон техникийн тусламж.

ХУУ-н үнэлгээний аргачлал


Үнэлгээний аргачлалыг боловсруулахад менежментийн гүйцэтгэлийг хянах, удирдлагын хяналтын аргуудыг ашиглах нь одоогийн МХЕГ-ийн нийцлийн үнэлгээг илүү сайжруулж хэрэгжилтээр эерэг үр дүнг гаргах боломжтой гэж үзсэн. ХУУ нь менежментийн арга хэрэгслийн хувьд ХУУ-г үнэлэх аргачлал нь тухайн компанийг хариуцлагатай ажиллахад тогтолцооны хувьд шаардлагатай бүрэлдэхүүн хэсгүүд байгаа эсэхийг үнэлэх замаар ХУУ-г хэрэгжүүлнэ. Зарим шаардлагууд нь удирдлагын хяналтын арга тохирохгүй байгаа тул тухай бүрт өөрөөр үнэлэх боломжит аргыг судалсан. Тухайлбал, нэмэлт оноог тухайн чиглэлийн сайн туршагыг хэрэгжүүлсэн бол авах боломжтой ч одоогоор алийг сайн туршлага гэх оролцогч талуудын ойлголтын зөрүү, судалгаа хомс, хэмжээ, боловсруулж буй ашигт малтмал, үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн нөхцөл байдлын хувьд харьцуулах бэрхшээлтэй байна. Тухайлбал, усны хэрэглээний хэмнэлтийг хэрхэн тооцох нь зэс, нүүрс, алтны уурхайд өөр өөр байна (*Ажиллах хүчний жишиг цалингийн хувьд ажилладаг мэргэжилтэнгүүдийн хийх ажлын үүрэг өөр өөр байх боловч нийтлэг ажлын байр болох уулын операторын цалинг харьцуулах боломжтой байж болно).

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ


Онооны хуваарилалтын шаардлагуудын тоог 100 хувиар дүйцүүлэн шилжүүлж үнэлнэ.

Шийдвэр	Хэрэгжүүлэлт	Мониторинг
Тухайн шаардлагатай холбоотой компанийн удирдлагаар баталгаажсан бодлого, журам, хөтөлбөр зэрэг баримт бичиг.	Батлагдсан төлөвлөгөө, санхүүжилтийг хамтад нь батлах.	Нөлөөллийг хэрхэн бууруулсан тухай үр дүн.

Зураг 5. ХУУ-г үнэлэх дараалал



Баталгаажуулсны дараа ХУУ-г үнэлэх баг өгөгдсөн мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна. Боловсруулагдсан дүгнэлтэд үндэслэн тухайн компанийн “Хариуцлагатай уул уурхайн индекс”-ийг гаргана.



Бүлэг тус бүрийн шаардлагуудыг 20% шилжүүлэх (100=20+20+20+20+20)

Үнэлгээг хийсэн аудитор, байгууллага тухайн уул уурхайн компанийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээнд үндэслэсэн хугацаатай хамтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэвэл зохистой. Хангалттай үнэлэгдээгүй, тогтолцоо нь хангагдаагүй гэж үзсэн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах хэсэгчилсэн сургалт, зөвлөгөөг мэргэжлийн байгууллага, зөвлөхөөр хийлгэх боломжтой. Үнэлгээг жил бүр тогтмол хугацаанд 2-3 удаа хийх бөгөөд шаардлагууд биелэгдсэн тохиолдолд жишиг шаардлагуудыг илүү сайжруулан гаргаж болно.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын олборлох салбарын хариуцлагыг сайжруулах боломжийг “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага, үнэлэх аргачлал”-аар үнэлж, хянаж, сайжруулах замаар жишиг стандарт болгон ашиглах явдал гэж үзэж болно. Монгол Улсын хариуцлагатай уул уурхайн туршлага болон олон улсын хариуцлагатай уул уурхайн туршлага, санаачилгуудыг харьцуулан компаниудын үйл ажиллагааг хариуцлагажуулах, ингэснээр компанийн урт хугацаан дахь ашиг орлогыг тогтвортой байлгах, удаан хугацаанд нөлөөтэй байх хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг хамруулахыг зорьсон. Харьцуулалтын үр дүнд: Компанийн засаглал ба ил тод байдал, Хүний эрх ба хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэнд, Байгаль орчны хамгаалалт, Орон нутгийн хөгжил ба олон нийтийн оролцоо гэсэн үндсэн 5 бүлэг (хамрах хүрээ)-ийг гаргаж, тухайлсан дэд бүлгүүдийг хамааралтай бүлгүүдэд шингээж нийт 34 дэд бүлэг 187 шаардлага боловсруулсан. Эдгээр шаардлагууд нь уул уурхайг хариуцлагатай ажиллуулахад зайлшгүй байх шаардлагатай менежментийн тогтолцоо буюу нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлдэг систем гэж олон улсын туршлагаар харуулсан байна.

Зураг 6. Хариуцлагатай уул уурхайн менежментийн тогтолцоо



Хариуцлагатай уул уурхайн шаардлагыг ихэвчлэн олон улсын байгууллагууд баталгаажуулалт, санхүүгийн эрсдлийг үнэлэх, хүний эрх, засаглалын сайн зарчмыг хангах зарчим болгон хөгжүүлсэн байх бөгөөд зарим улс орнууд тухайлбал, Канад, Австрали зэрэг улс орнууд эрсдлийн менежментийн тогтолцоо болгон хөгжүүлж өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглаж уул уурхайн төслийг амжилттай удирдаж байна. Монгол Улсын хувьд хариуцлагатай уул уурхайн туршлага хэдийгээр 2006 оноос эхлэлтэй боловч эдийн засаг, нийгмийн хөгжил тэр дундаа уул уурхайн салбарын хөгжлөөс хамаарч хариуцлагатай уул уурхайн ойлголт бүрэн дүүрэн тодорхойлогдоогүй буюу уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарах шууд болон шууд бус нөлөөллийг бүрэн хамааруулсан ойлголт дунд зэрэг байна.

Уул уурхайн бодлого боловсруулагч, шийдвэр гаргах түвшинд оролцогч талуудтай хийсэн ярилцлагад Ил тод байдал, орон нутгийн иргэдийн оролцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой шаардлагуудыг хамааруулан ойлгож байсан тул хариуцлагатай уул уурхайн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч уул уурхайн салбарын төрийн байгууллагуудад төдийгүй аймаг, сумдын захиргааны байгууллага, төрийн өмчийн уул уурхайн компаниудад шат дараатай сургалтуудыг хийж, сургалтын модулийг боловсруулахдаа хариуцлагатай уул уурхай, нийгмийн хариуцлага, засаглалыг үйл ажиллагааны эрсдэлтэй холбон тайлбарлах, кейс, судалгаануудыг оруулж зөв ойлголтыг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Уул уурхайн бизнес эрхлэгч, компаниудын хувьд дээрх ойлголтуудаас гадна компанийн засаглал тэр дундаа хуулийн нийцлийг хамааруулан авч үзэж байсан. Төрийн өмчийн компанийн хувьд болон жижиг уурхайн хувьд зөвхөн байгаль орчны нөхөн сэргээлт, осол авааргүй ажиллах, зарим тохиолдолд хандив, тусламжийн хүрээнд хариуцлагатай уул уурхайн ойлголттой байх тул хариуцлагатай уул уурхай, уул уурхайн тогтвортой хөгжлийн тайлан гаргах санаачилгыг гаргах, түүнийг нь урамшуулах, компаниудыг санаачилгатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төрийн байгууллагууд хяналт шалгалтын үндсэн үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг бүгдэд тэгш, жигд үйлчлэхэд анхаарахад шийдэмгийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Олон улсын туршлагаас харахад хариуцлагатай уул уурхайн санаачлага хувийн хэвшлийн зүгээс санаачилан хөгжүүлсэн байдаг нь компаниуд өөрсдөө эрсдлээ удирдахын тулд нийгэмдээ хүртээмжтэй байдлаар үйл ажиллагааг явуулах дундын зарчмаа

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

тохирохгүй бол бодлого боловсруулагчид бизнесийн салбарын эрх ашгийг тусгаагүй хатуу зохицуулалттай бодлого, хууль болгох замаар зохицуулалт хийх эрсдэл байдаг.

Хариуцлагатай уул уурхайн шаардлагыг хэрэгжүүлэхэд дараахь алхамуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

1. Хариуцлагатай уул уурхайн шаардлагуудыг хэрэгжүүлэхийн тулд хэн, ямар зорилгын хэрэгжүүлэх гэж буйг тодорхойлох. Судлаач миний зүгээс компаниуд өөрсдийнхөө төлөө энэхүү санаачлагыг бий болгоход ОУБ, хандивлагч орнуудын хандив, тусламж дэмжлэгтэйгээр чадамжтай мэргэжлийн холбоог түшиглэн хэрэгжүүлэх.
2. Хариуцлагатай уул уурхайн үнэлгээг хийх аудиторуудыг мэрэгшүүлэх, бэлтгэх сургалт зохион байгуулах.
3. Төрийн байгууллага, олон нийтэд хариуцлагатай уул уурхайн талаарх зөв цэгцтэй мэдээлэл өгөх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

Хариуцлагатай уул уурхайн шаардлагуудыг 2 жил тутамд шинэчилэн сайжруулж хөгжлийн орчинд нийцүүлж байх шаардлагатай. Ингэснээр хариуцлагатай уул уурхайн Монгол Улсын нөхцөлд тохирсон зохистой шаардлагыг зохистойгоор хэрэгжүүлж уул уурхайн салбарын засаглал бэхжиж, хүний эрхийг дээдэлсэн нийгмийг бий болгох, байгаль орчны сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгаж хойч үеийн хэрэгцээ шаардлагыг хязгаарлахгүйгээр тогтвортой хөгжих боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ХАМРАХ ХҮРЭЭ БА ШААРДЛАГА

Хамрах хүрээ:

1. Компанийн сайн засаглал ба ил тод байдал
2. Хүний эрхийг хангах ба хөдөлмөрийн харилцаа
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэнд
4. Байгаль орчны хамгаалал
5. Орон нутгийн хөгжил ба олон нийтийн оролцоо

Шалгуур үзүүлэлтүүд:

1. КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛ БА ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ШААРДЛАГА

Компани сайн засаглалын шаардлага нь компанийн төрлөөс хамаарч өөр өөр байж болох тул засаглалын хувьд байх шаардлагатай ерөнхий шаардлагууд болон ОҮИТБС-ыг дэмжин ажиллах ил тод байдлын ерөнхий шаардлагуудыг багтаасан. Компанийн засаглал гэдэг нь компанийн үйл ажиллагаанд хяналт болон зохистой удирдлагыг хэрэгжүүлэх тогтолцоог би болгох, улмаар тасралтгүй боловсронгуй болгох үйл явцыг ойгоно. Ил тод байдлыг хангана гэдэг нь тухайн компанийн талаар болон уурхайтай холбоотой, хуулиар хориглоогүй мэдээллийг сонирхсон этгээд чөлөөтэй үзэж байх нөхцлийг бүрдүүлэхээс гадна шаардлагатай зарим мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр мэдээллийн самбар, цахим хуудас, уулзалт ярилцлага болон хэвлэмэл байдлаар хүргэх үйл ажиллагааг ойлгоно.

Дараахь мэдээлэл нь ил тод байх шаардлагатай:

1.1 Компанийн тухай үндсэн мэдээлэл:

- 1.1.1 Компанийн албан ёсны нэр, регистрийн дугаар.
- 1.1.2 Компанийн статус, төрөл, үндсэн үйл ажиллагааны мэдээлэл
- 1.1.3 Албан ёсны хаяг, холбогдох утас, цахим шуудангийн хаяг.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

- 1.1.4 Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийн мэдээлэл (овог нэр, албан тушаал, зураг)
- 1.1.5 Гүйцэтгэх захирлын мэдээлэл (овог нэр, албан тушаал, зураг)
- 1.1.6 Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүнийн мэдээлэл (овог нэр, албан тушаал, зураг)
- 1.1.7 Хувь, хувьцаа эзэмшлийн мэдээлэл (эзэмшлийн төрөл, хэмжээ, саналын эрх)
- 1.1.8 Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаар ба өргөдөл, гаргасан, олгосон, дуусах огноо.
- 1.1.9 Лиценз, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, зураг зүйн бүртгэл дээрх солбилцол.
- 1.2 Компанийн засгийн газар болон түүнийг төлөөлөх эрхтэй байгууллагатай хийсэн хөрөнгө оруулалт, тогтвортой байдал, концессийн гэрээний нөхцлүүдийг ил тод болгосон байх.
 - 1.2.1 Засгийн газрын хувьд ноогдох ашиг
 - 1.2.2 Ашгийн татвар
 - 1.2.3 Нөөцийн төлбөр
 - 1.2.4 Ногдол ашиг
 - 1.2.5 Лиценз түрээсийн төлбөр, концесстой хамаарах бусад төлбөр.
 - 1.2.6 Засгийн газрын хүртэж буй бусад томоохон хэмжээний орлого болон материаллаг үр шим.
- 1.3 Компанийн тайланг компанийн цахим хуудсанд болон Засгийн газрын тохиромжтой цахим хуудсанд байршуулан ил тод байх ба тайланд дараахь мэдээлэл хүртээмжтэйгээр оруулсан байх.
 - 1.3.1 Бүтээгдэхүүний төрөл, тэдгээрийн нөөц ба үйлдвэрлэлийн хэмжээ.
 - 1.3.2 Компанийн орлого, ашиг, зардал.
 - 1.3.3 Засгийн газар болон бусад төрийн байгууллага, ТББ, иргэнд шилжүүлсэн шилжүүлэг, мөнгөн төлбөр, хандив, тусламж, бараа материалын хэмжээ, хүлээн авсан байгууллага, иргэн бүрээр гаргадаг эсэх.
 - 1.3.4 Бүтээгдэхүүний тээврийн зардалд зарцуулсан хэмжээ.
 - 1.3.5 Гаалийн албан татвар.
 - 1.3.6 Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.

- 1.3.7 Газрын төлбөр.
- 1.3.8 Ус бохирдуулсны төлбөр.
- 1.3.9 Агаарын бохирдлын төлбөр.
- 1.3.10 Ус ашигласны төлбөр.
- 1.3.11 Хувь хүний орлогын албан татвар.
- 1.3.12 Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.
- 1.3.13 Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр.
- 1.3.14 Хог хаягдлын үйлчилгээний хураамж.
- 1.3.15 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр.
- 1.3.16 Ажилчны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл.
- 1.3.17 Компанийн нийт төлсөн татварыг улс, аймаг, сумаар ангилан олон нийтдээ ил тод болгодог эсэх.
- 1.4 Компани хяналт шинжилгээ, үнэлгээний дотоод хяналтын функцтэй байх.
 - 1.4.1 Нийцлийн хяналт хийдэг эсэх.
 - 1.4.2 Гүйцэтгэлийн хяналт хийдэг эсэх.
 - 1.4.3 Санхүүгийн хяналт хийдэг эсэх.
 - 1.4.4 Засаглалын хяналт хийдэг эсэх.
 - 1.4.5 Эрсдлийн үнэлгээний хуудас, төлөвлөгөөтэй байх.
 - 1.4.6 Төлөвлөгөөний дагуу хяналт, үнэлгээ хийсэн тухай тайлан, зөвлөмж боловсруулдаг байх.
 - 1.4.7 Хяналт үнэлгээгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авдаг эсэх.
- 1.5 Компани авилгын эсрэг бодлоготой байж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж хэрэгжүүлдэг байх.
 - 1.5.1 Ашиг сонирхолын зөрчлийн үнэлгээг удирдлага, удирдлагын баг, чухал шийдвэр гаргалтад оролцдог ахлах мэргэжилтнүүдийг хамруулан хийдэг байх.
 - 1.5.2 Удирдлагуудыг сургалтанд хамруулдаг байх. Сургалтын хэрэгцээний талаарх үнэлгээний хуудсыг бөглүүлдэг байх.
- 1.6 Компани санал гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх хүртээмжтэй функцтэй байх.

- 1.6.1 Санал гомдлыг компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ашигладаг соёлыг тогтоож байгаа эсэх.
- 1.6.2 Санал гомдол гаргах, хүлээн авах шийдвэрлэх, хариу өгөх үйл явц хүртээмжтэй, ил тод байх.
- 1.6.3 Санал гомдол гаргагч өөрөө хүсвэл нэрээ нууцалж болдог байх.
- 1.6.4 Санал гомдол нь бүртгэгдэж түүх үүсэж байгаа эсэх.
- 1.6.5 Санал гомдол гаргах үйл явцыг оролцогч талуудаар хэлэлцүүлж санал авдаг байх. Санал гомдолд хариу өгч санал гомдлыг хаах цаг хугацаа хязгаартай байх зохицуулалттай эсэх.
- 1.7 Компани нь мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг явуулдаг байх.
 - 1.7.1 Ёс зүйн хороотой, ёс зүйн хороо ажиллах журамтай байх.

2. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ БА ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ШААРДЛАГА

- 2.1 Хүний эрхийг хүндэтгэх тухай компаниас гаргасан бодлоготой байх.
 - 2.1.1 Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн зөвлөхийн хамт 2 жил тутам хийж тайлан гаргадаг байх. Тайлангийн дагуу хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлдэг байх. Тайланд дараахь агуулгыг заавал багтаасан байх. Үүнд:
 - 2.1.2 Үнэлгээний аргачлалтай байх.
 - 2.1.3 Улсын болон тухайн бүс нутгийн хүний эрхийн асуудлыг тодорхойлсон байх.
 - 2.1.4 Эрх нь зөрчигдөж болох бүлгүүдийг тодорхойлох (хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон цөөнхийн төлөөлөл г.м.)
 - 2.1.5 Компанийн үйл ажиллагаанаас шалтгаалсан хүний эрх зөрчигдөж болзошгүй үзэгдлүүдийг тодорхойлох.
 - 2.1.6 Болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ба одоо байгаа хүний эрхийг зөрчсөн үзэгдлийг арилгах арга хэмжээний зөвлөмж.
- 2.2 Үйлдвэрчний эвлэлтэй хамтын гэрээ байгуулсан байх. Жил бүр хамтын гэрээний хэрэгжилтийн тайланг ажилчдад танилцуулдаг байх.

- 2.2.1 Үйлдвэрчний хороо хуралдахад тохиромжтой байнгын өрөөтэй байх.
- 2.2.2 Хорооны ажилчдад шаардлагатай мэдээллийг гаргаж өгдөг байх.
- 2.2.3 Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр саад учирлуулахгүй ажилчдыг үйлдвэрчний эвлэлд нэгдэхэд гадуурхах хандлага, үйлдлийг гаргадаггүй байх.
- 2.3 Хүний нөөцийн бодлого, ажилтан сонгон шалгаруулалтын журам, цалин урамшууллын журам, сургалт, мэргэжил дээшлүүлэхэд туслах журам, хөтөлбөртэй байх.
 - 2.3.1 Ажлаас гарсан, халагдсан ажилтны жагсаалт гаргаж анализ хийдэг эсэх.
 - 2.3.2 Ажлын нөхцөл, ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан бичиж хөдөлмөрийн гэрээтэй хавсаргасан байх.
 - 2.3.3 Санал гомдол гаргах шат дараалал ажилтанд энгийн ойлгомжтой, итгэл төрүүлэхүйц байх. Ажилд орох үед танилцуулсан байх.
 - 2.3.4 Ажилтантай холбоотой ирсэн, гаргасан гомдлын жагсаалтыг бүртгэдэг байх.
 - 2.3.5 Ажилтны цалингийн хэмжээ амьдралын үндсэн хэрэгцээг хангахад хүрэлцээтэй байх.
 - 2.3.6 Илүү цаг ажилласны хөлсийг олгодог эсхүл нөхөн амруулдаг байх. Үүнийг зохицуулсан ойлгомжтой зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байх.
- 2.4 Компани цомхогтголоос үүдэн гарах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг гаргасан байх. Өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлдэг байх.
 - 2.4.1 Нийт ажилчидад танилцуулж, хуулийн дагуу мэдэгдсэн байх.
 - 2.4.2 Цомхотгол шудрага, алагчлалгүй байх.
- 2.5 Ажилтан шинээр хүүхэдтэй болсноос хойш өөрөө хүсвэл 4 хүртэл долоо хоногийн цалинтай чөлөө олгодог байх. Үүнийг зохицуулсан ойлгомжтой зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байх.

3. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНДТЭЙ ХОЛБООТОЙ ШААРДЛАГА

- 3.1 Компани нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах цогц дүрэм журам, эрсдлийн үнэлгээ, түүнийг хэрэгжүүлдэг төлөвлөгөөтэй байх.
- 3.1.1 Уурхай дээрх аюултай ажил, болзошгүй үзэгдлийг тодорхойлсон байх.
- 3.1.2 Аюултай ажлын эх үүсвэрийг хянадаг байх.
- 3.1.3 Аюултай ажлын илрүүлэлт дээр үндэслэн ажлын байрыг аюулгүй байлгах тогтолцоо, системийг бий болгосон байх.
- 3.1.4 Хувийн хамгаалалт хэрэгслээр хангагдсан байх.
- 3.2 Аюулыг илрүүлж эрсдлийг үнэлэхдээ дараах үндсэн чиглэлийг хамааруулдаг байх.
- 3.2.1 Уулын цул (хайрга, нүүрс, хүдэр, жонш г.м) олборлох үйл ажиллагаа, өрөмдлөг, тэсэлгээ, уулын цул тээвэрлэлт, ажлын зохион байгуулалт, машин тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, химийн бодисын хадгалалт болон хаягдалтай холбоотой болзошгүй аюулын жагсаалт гаргасан эсэх.
- 3.2.2 Гадны байгууллага, гэрээлэгч компаниуд, уурхайн зочид, хөрөнгө оруулагч болон үндсэн ажилтанууд уурхайд аюулгүй зорчдог журам, заавар тогтмол өгдөг эсэх.
- 3.2.3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа ба туслах үйл ажиллагааны явцтай холбоотой болзошгүй аюулын жагсаалт гаргасан эсэх.
- 3.2.4 Үйлдвэрлэлийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн урсгал болон гэнэтийн засвар үйлчилгээнд тохиолдож болох эрсдлийг тооцдог эсэх.
- 3.3 Уул уурхайн олборлогч компаниуд нь дараах хэмжилтүүдийг хийж байнгын хяналт явуулдаг байх.
- 3.3.1 Цахилгааны болон механик тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал,
- 3.3.2 Холбооны хэрэгсэл,
- 3.3.3 Ажлын байрны аюултай хортой хүчин зүйлийн хэмжилт

- 3.3.4 Агааржуулалтын бүрэн бүтэн байдал ба тэдгээрийн хэвийн ажиллагаа.
- 3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны үл тохирол /зөрчил дутагдал/-ыг илрүүлэх хяналт, мониторингийн журам боловсруулж хэрэгжүүлдэг эсэх.
- 3.4.1 Гүйцэтгэлийн хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлон гаргасан эсэх.
- 3.4.2 Нэгж ба ажилтнуудын гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтийн дагуу тогтмол хэмждэг эсэх.
- 3.5 Дотоод аудит хийх журам боловсруулж хэрэгжүүлэх, тогтолцооны хэрэгжилтийг тогтсон завсарлагатайгаар дүгнэж, дээд удирдлагын дүн шинжилгээ хийлгэдэг эсэх.
- 3.5.1 Ажилтныг санал гомдол, санаачлага гаргах бололцоогоор хангах, аюулыг мэдээлэх, аюулыг мэдээлсэн ажилтныг урамшуулдаг механизмтай эсэх.
- 3.6 Байгууллага нь ажилтан болон ажил олгогчоос бүрдсэн ХАБЭА-н орон тооны бус зөвлөлтэй байх бөгөөд дараах чиг үүргийг баримтлаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажилладаг байх.
- 3.6.1 Ажлын байрны эрсдэлтэй хүчин зүйлс, тэдгээрийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил хийдэг эсэх.
- 3.6.2 ХАБЭА-н хяналт, ажлын байрны хортой хүчин зүйлсийн хэмжилт, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлтийг бууруулах арга замыг тогтоодог эсэх.
- 3.6.3 Уурхайн төлөвлөгөөг хэлэлцэх үед ажлын байрны аюултай, хортой хүчин зүйлийг бууруулахад чиглэгдсэн төлөвлөгөөг хэлэлцүүлж хянадаг эсэх
- 3.6.4 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, нөлөөнд өртсөн үед ослыг дахин давтагдахгүйн үүднээс аюулын үндэс суурийг бүрэн арилгах ажлыг хянадаг эсэх.
- 3.6.5 Аливаа аюул осол, техникийн бүрэн бүтэн байдал алдагдах ажилтны буруугаас үүдсэн хохиролд үл буруутгах зарчмыг баримтлах, уг асуудлын үндэс суурийг тогтоож илрүүлдэг эсэх.
- 3.7 Онцгой байдалд бэлэн байх, хариу үзүүлэх журам боловсруулж хэрэгжүүлэх, онцгой байдлын төлөвлөгөө гаргасан байх.

- 3.7.1 Ил болон далд уурхайн аваар устгах төлөвлөгөөг жил бүр хянан баталж сайжруулах. Уурхайд аваар осол гарсан үед ямар арга хэмжээ авах талаар дэс дарааллыг цагийн байдалд тулгуурлан үнэн бодитоор боловсруулсан эсэх.
- 3.7.2 Гамшиг, онцгой байдлын үед анхны тусламж үзүүлэх, барилга байгууламжийн нуранги, осолдогчид анхны тусламж үзүүлэх, гэмт халдлага, болзошгүй байгалийн гамшигт үзэгдлийн үед авах арга хэмжээний дэс дараалал, шаардлагатай техник тоног төхөөрөмж, хүн хүчний тооцоо, жагсаалтыг гаргасан байх ёстой бөгөөд эдгээр сайн дурын бүлгэмүүдийг жилд нэгээс доошгүй удаа бэлтгэл сургуулилт хийж бодит жишээн дээр тулгуурласан даалгаварын дагуу аврах ажиллагааны сургуулилтийг зохион байгуулдаг эсэх.
- 3.7.3 Аюултай хортой хүчин зүйлсийн талаар сургалт зохион байгуулдаг байх, тэдгээрээс хэрхэн сэргийлэх талаар дадлага сургуулилт хийдэг байх. Гал унтраах техникийг эзэмших, тэсэлгээний үед авах аюулгүй арга хэмжээнд сургадаг эсэх.
- 3.8 Сургалтыг тогтмолжуулах, чанарыг сайжруулах.
- 3.8.1 Ажилтан аюултай тохиолдол болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, гэмтэл, бэртэлд өртсөн үед тэдгээрийг нуун дарагдуулахгүйгээр удирдах ажилтанд мэдээлэх бололцоогоор хангасан соёлыг дэмждэг байх. Мэдээлсэн тохиолдолд ажилтанд дарамт учруулдаггүй байх, аюулыг илрүүлж эрсдлийг үнэлэх мэдлэг, боломж бололцоогоор хангах сургалтад хамруулдаг эсэх.
- 3.8.2 Ажилтнуудад шаардлагатай ур чадвар, мэдлэг ба сургалтын хэрэгцээг тодорхойлж, ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт хохирол учруулах аюултай, хортой нөхцлийг арилгах талаар сургалт, сурталчилгаа хийдэг эсэх.
- 3.8.3 Залруулах ба сэргийлэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг тогтолцоог ажиллуулахын тулд ажилтнуудыг эрсдлийн үнэлгээ, сургалт, хэрэгжүүлэлт, шийдвэр гаргалтанд оролцуулах, тэдэнтэй зөвлөлддөг тогтмол уулзалт буюу хэлэлцүүлгийг хийдэг соёлтой эсэх.

- 3.9 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зориулалтаар нь зарцуулсан тухай тайланг гаргадаг эсэх.
- 3.9.1 Уул уурхайн олборлогч компаниуд нь аюул хор хөнөөлийн үндсэн суурь шалтгааныг арилгахын тулд шинэ техник нэвтрүүлэх, технологийн процессийг өөрчлөх, барилга байгууламжийн хийцийг өөрчлөх зардалд санхүүгийн нөөцийг төлөвлөдөг эсэх.
- 3.10 Уул уурхайн компаниуд нь хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан, эрүүл мэнд болон эрүүл ахуй хариуцсан ажилтанг тус тусад нь ажиллуулдаг байх.
- 3.11 Уурхайн ажилчид, уурхайн шууд нөлөөлөлд өртөх иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт төлөвлөгөөтэйгээр хамруулдаг байх.
- 3.12 Уул уурхайн олборлогч компани нь үйлдвэрлэлийн осол болон хурц хордлогод нэрвэгдсэн ажилтныг эдгэрэх хүртэлх хугацааны бүх зардлыг гаргах, гэмтлийн зэргээс хамаарч ажлаа гүйцэтгэх боломжгүй тохиолдолд алдсан хоногийн цалин, нөхөн төлбөрийг тооцож олгодог байх.
- 3.13 Аюултай эрчим хүчний эх үүсвэрийг тусгаарлаж, пайз цоожны системийг хэрэглэдэг эсэх.
- 3.14 Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх, хадгалах, ашиглах нөхцөлд тухайн бодисын эрсдлийн үнэлгээг заавал хийлгэсэн байх.
- 3.15 Болзошгүй аюултай хортой хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх анхааруулах плакат, зурагт хуудас, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан байх.
- 3.16 Туслан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд ХАБАЭ-ийн талаарх эрх, үүрэг хариуцлагыг тусган хэрэгжүүлэлтэд хяналт тавих нөхцлийг гэрээнд тусгадаг эсэх.
- 3.17 Эрсдлийн талаар ажилчид болон гэрээт гүйцэтгэгчид мэдээлэх ба тэд холбогдох журмын талаар сургалт, мэдээлэл авсан эсэхийг хянах дотоод аудитын процесстой эсэх."

4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШААРДЛАГА

4.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр бүхий л төрлийн нөлөөллийг илрүүлж нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалахад зорилусан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг байх.

4.1.1 Усны ерөнхий шаардлага:

4.1.1.1 Усны менежментийн төлөвлөгөөг салбарын мэргэжилтэнүүдийн оролцоотойгоор боловсруулж үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд мөрдүүлдэг эсэх.

4.1.1.2 Орон нутгийн иргэдийн уламжлалыг хүндэтгэсэн усны мониторингийн хамтарсан хөтөлбөр бий болгож, усны мониторингийн тайланд худгийн усны түвшин болон чанарын талаарх мэдээлэл тусгадаг эсэх.

4.1.1.3 Үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй сөрөг нөлөөлийг хянах усны мониторингийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг эсэх.

4.1.1.4 Гадаргын болон газрын доорх усны чанарыг хэвийн хэмжээнд хадгалах эсвэл сайжруулах усны мониторинг тогтмол хийдэг эсэх (суурь судалгааны үр дүнтэй харьцуулах).

